



СОЁЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ

Тогтвортой ноолуурын ёсзүйг тайлах нь

Монгол улсад ноолуурын салбарыг
хөгжүүлэх чиглэлд төрөөс хэрэгжүүлж буй
бодлого, эрх зүйн орчны тойм лавлагаа

Соёл-Хүний Хөгжил Судалгааны Төв

Энэхүү тайланг Канад Улсын Нийгэм, Хүмүүнлэгийн Шинжлэх Ухааны Хорооны санхүүжилтээр ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, Канадын Виннипегийн их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “ТОГТВОРТОЙ НООЛУУР: ЁС ЗҮЙГ ТАЙЛАХ НЬ” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Удирдсан:

Х.Наранцацрал (Хуульзүйн үндэсний хүрээлэн)

Эрик Трифт (Виннипегийн Их Сургууль)

Улаанбаатар хот

2024 он

ТОВЧ ТАЙЛАН	1
Удиртгал	1
Ноолуурын салбарт төрөөс хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн лавлагаа	4
Нэг. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт ноолуурын салбарт	5
Гаалийн албан татварын чөлөөлөлт	6
Хоёр. Ноолуур хөтөлбөр (2000-2006 он)	6
Гурав. “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр	8
Дөрөв. Ноолуур хөтөлбөр (2018-2021)	13
Тав. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичиг	17
Зургаа. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг	18
ТӨРӨӨС НООЛУУРЫН САЛБАРТ ОРОЛЦОГЧДЫН ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛД 2000 ОНООС ХОЙШ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУХАЙЛСАН АРГА ХЭМЖЭЭ	19
Нэг. Ноолуур бэлтгэн нийлүүлэгч малчдад чиглэсэн буюу ноолуурын үнийн талаарх бодлого, шийдвэр	19
Хоёр. Ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн бодлого, шийдвэр	23
Гурав. Ноолууран бүтээгдэхүүний худалдаа экспортыг нэмэгдүүлэх чиглэсэн бодлого, шийдвэр	32
Дүгнэлт	40
Хураангуй	45
Хавсралт	46
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	46
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ	53

ТОВЧ ТАЙЛАН

Удиртгал

Аливаа улс орны нийгмийн амьдралын үндсийн үндсийг тодорхойлогч нь эдийн засгийн харилцаа байдаг бөгөөд түүнийг тухайн орны эдийн засгийн тогтолцоогоор илэрхийлдэг. Монгол Улс 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр шинэ, ардчилсан Үндсэн хуулийг¹ баталснаар дэлхийн улс орнуудын хүлээн зөвшөөрсөн зах зээл, чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэн билээ.

Ийнхүү шинэ, ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улс эдийн засгийн харилцааны хувьд нийтийн өмчид суурилсан аж ахуйн социалист тогтолцоо дангаар ноёрхож байсныг халж, олон хэвшилт эдийн засагтай болох харилцааг хуульчлан баталгаажуулсан. Шударга өрсөлдөөнд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн харилцааг тогтоож, түүнд төрийн оролцоог хязгаарлаж өгсөн. Хувийн ба нийтийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрийн өмчийг задлан хувьчлах, иргэд хувийн аж ахуй эрхлэх эрх зүйн үндсийг тогтоож өгсөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлд² Монгол Улсын эдийн засгийн тогтолцоог дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийн харилцаа байхаар хуульчлан бэхжүүлсэн. Дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага гэдэг бол хүн

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны №1-т нийтлэгдсэн. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

² Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.

төрөлхтөний түүхэн хөгжлийн явцаар шалгарч бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зах зээлийн эдийн засгийн харилцаа юм. Ийм харилцааг бүрдүүлж хөгжүүлэхдээ Монгол Улсынхаа эдийн засгийн бүтэц, хүчин чадал, уламжлалт харилцаа, учирч байсан саад бэрхшээлээс эхлээд газар нутаг, цаг уурын өвөрмөц байдал, хүний хүчин зүйл зэргийг бүх талаас нь харгалзан үзэж шийдвэрлэж байхыг өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэх гэдэг томъёоллоор хуульчилсан байна.³

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн гол чухал нөлөөлөгч хүчин зүйл нь хөдөө аж ахуйн тэр дундаа бэлчээрийн мал аж ахуйд суурилсан мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ голлох байр суурийг эзэлдэг.

Тийм учраас мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих чиглэлд төрөөс олон тооны бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлдэг. Үүнийн гол суурь буюу тод илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 4-т “төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, 5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна.” гэж зааж өгснөөс харж болно.

Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах асуудал бол ардчилсан төрийн Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүрэг бөгөөд тэр үүргээ хэрэгжүүлэхийн тулд зах зээлийн эдийн засгийн нийтлэг харилцаатай өөрийн орны хөгжлийн онцлогийг нийцүүлэн эдийн засгийг зохицуулах аргаар хэрэгжүүлнэ.

Мал сүрэг төрийн хамгаалалтад байх тухай ойлголт нь Монгол орны цаг уурын эрс тэс нөхцөл, монголчуудын мал сүрэгээ бэлчээрээр адгуулдаг уламжлалт нүүдлийн соёл иргэншил, тэр бүгдтэй зохицсон монгол малын онцгой тэсвэр хатуужилтай өвөрмөц ашиг шим бүхий удмын санг хамгаалах зэрэг олон зүйл багц асуудлаар малчдад төрийн зүгээс үзүүлэх эдийн засаг, эрх зүйн болон шинжлэх ухааны өргөн тусламж үзүүлж төр засгийн үүрэг болгон Үндсэн хуулийн хэмжээнд хуульчлан бататгасан нь Монголын онцлог юм.⁴

³ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Зох. Г.Совд нар., Уб., 2000. 41-42 дахь тал

⁴ Мөн тэнд 45-46 дахь талд

Тийм учраас мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт төрөөс олон зорилтод хөтөлбөр, бодлогын шинжтэй эрх зүйн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлж иржээ. Түүний нэгээхэн хэсэг нь төрөөс ноос, ноолруурын салбарт хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, эрх зүйн баримт бичгийн нэлээдгүй хувийг ноолуурын салбарт хамаарах баримт бичиг, түүгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хамаарч байна.

Монгол Улс ямаа, тэмээний ноолуурыг үйлдвэрийн аргаар боловсруулах асуудлыг 1970-аад оны эхэн үе хүртэл хөндөж байгаагүй. 1978 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байгууллагад ноолуурыг үйлдвэрийн аргаар боловсруулан экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх тухай хандсанаар асуудал шийдэгдэж, жилд 35.000 ширхэг ямааны ноолуур, тэмээний ноосон сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай “Туршилтын үйлдвэр” ашиглалтанд орсон билээ. Ингэснээр Монгол Улс анх удаагаа ямаа, тэмээний ноолууран бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн талаар судлаачид дурджээ.⁵

Энэхүү бэсрэг судалгааны ажлын хамрах цаг хугацааны хувьд шинэ, ардчилсан Үндсэн хууль 1992 оны батлагдсанаар Монгол Улс эдийн засгийн харилцааны хувьд нийтийн өмчид суурилсан аж ахуйн социалист тогтолцоо дангаар ноёрхож байсныг халж, олон хэвшилт эдийн засагтай болох харилцааг хуульчилан баталгаажуулж зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс хойш ноолуурын салбарт төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр үйл ажиллагаа тэр дундаа голлох бодлогын шинжтэй баримт бичгүүдийн хүрээнд судалсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Энэ нь ноолуурын салбарт төрөөс авч хэрэгжүүлсэн томоохон бодлогын баримт бичиг болох Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоолоор батлагдсан “Ноолуур хөтөлбөр (2018-2021) тэдгээрийг дагаж авч хэрэгжүүлсэн олон бодлогын шийдвэр,

⁵ Ж.Мөнхгэрэл, Ж.Батжаргал, Б.Нармандах “Ноолуурын үнэ, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах, ноолууран эдлэлийн борлуултыг нэмэгдүүлэх нь” ШУТИС-Компютерийн техник Менежментийн сургууль нийтлэгдсэн цахим эх сурвалж: <https://www.slideshare.net/batnasanb/ss-31068739> сүүлд үзсэн: 2022.12.20

эрх зүйн актын зохицуулалтын хүрээнд цаг хугацаа үйлчлэлийн хувьд хамруулахыг зорьсон болно.

Түүнчлэн судалгаанд хамаарах эрх зүйн актыг Монгол Улсын эрх зүйн мэдээллийн албан ёсны нэгдсэн систем буюу www.legalinfo.mn цахим сангаас ашигласан болно.

Ноолуурын салбарт төрөөс хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн лавлагаа⁶

Ноолуур бол Монгол Улсын стратегийн чухал бүтээгдэхүүн болохыг төрийн бодлогод тодорхойлж, ноолуурын салбарын хөгжлийг түргэсгэх уг салбарын зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа, оролцоог дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд төрөөс чамгүй олон бодлогын баримт бичиг, хөтөлбөр, холбогдох эрх зүйн актыг баталжээ.

Монгол Улсад ноолуурын салбарт төрөөс авч хэрэгжүүлсэн томоохон бодлогын баримт бичиг нь Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дахь хөнгөлөлт чөлөөлөлт болон Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоолоор батлагдсан “Ноолуур хөтөлбөр (2018-2021), “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн №36 тогтоол “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2018-2021) үндэсний хэмжээнд хэрэгжсэн энэ салбарын томоохон бодлогын баримт бичгийн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөөний талаар зайлшгүй эхлэн авч үзэх нь зүйтэй болов уу.

⁶ Лавлагаа хэмээсний учир нь эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлын хүрээнд ямар түвшинд хэрхэн яаж өөрчлөгдсөнийг, ямар зохицуулалт агуулсныг л тусгасан болно. Өөрөөр хэлбэл анализ дүн шинжилгээ хийх шүүмжлэлтэй хандах, эсхүл эерэг болон сөрөг дүгнэлт өгөх, академик санал дэвшүүлэх зэрэг зорилго шууд агуулаагүйд оршино.

Манай улс малын гаралтай түүхий эдийг эхний үе шатанд 40, дараагийн үе шатанд 60 хувь хүртэл гүн боловсруулж нэмэгдүүлэх талаар “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгүүддээ тусгасан. Дээр нь Засгийн газраас 2018 онд “Үйлдвэржилт-21”, “Ноолуур”, “Монгол экспорт” зэрэг хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийг боловсруулж гаргасан.

Нэг. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт ноолуурын салбарт

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай 2015.07.09-ний өдөр батлагдсан хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Дараах барааг албан татвараас чөлөөлнө: 13.1.21.экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир; гэж заажээ. Өөрөөр хэлбэл монгол улсаас бусад улсад гаргаж буй түүхий болон угаасан, самнасан ноолуурыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалттай ажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 14.1.4 дэх заалтад “хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр”-ийг нэмж өөрчлөлт оруулсан. Мөн хуулийн 14.2-т “14.1.4-т заасан анхдагч түүхий эдийг импортоор оруулсан буюу худалдан авч дамжуулан борлуулсан бол төлбөл зохих албан татвараас хасалт хийхгүй. Хоршоо гишүүнийхээ энэ хуулийн 14.1.4-т заасан барааг дотоодын үйлдвэрлэгчид зуучлан борлуулсан бол дамжуулан борлуулсанд тооцохгүй” гэсэн нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулжээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас тухайлсан нэг удаагийн тохиолдолд Монгол Улсын тодорхой салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, Засгийн газраас энэ төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж буй иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай зарим тоног, төхөөрөмжийг гадаад улсаас оруулж ирэхэд тодорхой хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг баталж тухайн тохиолдолд хэрэгжүүлдэг.

Тухайлбал, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн хуулийг баталжээ.

Гаалийн албан татварын чөлөөлөлт

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас тухайлсан нэг удаагийн тохиолдолд Монгол Улсын тодорхой салбарын үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, Засгийн газраас энэ төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж буй иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай зарим тоног, төхөөрөмжийг гадаад улсаас оруулж ирэхэд тодорхой хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг баталж тухайн тохиолдолд хэрэгжүүлж иржээ. Үүний нэг илрэл нь 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр зохицуулсан хуулийг баталжээ.

Хоёр. Ноолуур хөтөлбөр (2000-2006 он)

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2000 оны үндсэн чиглэлд "Ноолуур" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсаныг үндэслэл болгож тус хөтөлбөрийг Засгийн газраас баталжээ.

Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2000 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн №50 тогтоолоор

“...”а./Ноолуур” хөтөлбөрийг 2000 оны II улиралд багтаан боловсруулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдад үүрэг болгосугай” гэж шийдвэрлэжээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөрийг 2000-2004 онд хэрэгжүүлэхээр баталжээ.⁷ Тус хөтөлбөрийг гурван үе шаттайгаар 2001-2006 оныг хамруулан хэрэгжүүлэхээр тусгажээ.

Тус хөтөлбөрт зааснаар хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг дараах байдлаар тодорхойлжээ.

а/. түүхий эдийн экспорт багасаж, түүнийг дотооддоо боловсруулах хүчин чадал нэмэгдэж бүтээгдэхүүний үйлдвэрлэл өснө;

б/. ноолууран бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, үйлдвэр, аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадавхи сайжирна;

в/. ноолууран бүтээгдэхүүний нэр төрөл олширч, загвар хийц дээшилнэ;

г/. дэлхийн зах зээлд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүний тоо нэмэгдэнэ гэж заажээ.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

1. Ямаан сүргийн тооллого явуулж, монгол үүлдрийн ямааны омог хэвшлийн тоо, хувийн жин, сүргийн бүтэц, тархалтын хүрээ, ямааны үүлдэрлэг байдлыг сум бүрээр тодорхойлсон
2. Үржлийн шилмэл ямааны цөм сүргийг бүрдүүлж бүртгэлжүүлэх, бүс нутгийг тогтоох, мэдээ
3. Цөм сүргийг түшиглэж стандартын шаардлага хангасан үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулах иргэн, хуулийн этгээдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжсэн
4. Говь гурван сайхан, Уулын бор ямааны селекцийн бодлогыг тодорхойлж, тэдгээрийн цөм сүргийг сайжруулах арга хэмжээ авсан
5. Түүхий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн

⁷ Тус хөтөлбөрийг бүрэн эхээр нь тус холбоосоос үзнэ үү.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=201406&showType=1>

6. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн бодлогыг хэрэгжүүлсэн
7. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад туслах материалыг импортлох үйл ажиллагааг эдийн засгийн аргаар дэмжсэн
8. Ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн иж бүрдэл үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжид эдийн засгийн хөнгөлөлт үзүүлэх эрх орчинг бүрдүүлэх
9. Эх орны ноолуурын үйлдвэрүүдийн хүчин чадлыг сэргээх, ашиглах, нэмэгдүүлэх үйл ажиллагааны тухайн үеийн байдалд нийцүүлж түүхий ноолуурын экспортыг уян хатан байдлаар зохицуулах, шаардлагатай үед тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судалж шийдвэрлэсэн гэжээ.

Засгийн газрын 2000 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөрийг 2000-2004 онд хэрэгжүүлсний үр дүнд ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт эрчимтэй өсч, тухайн үеийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмрийг оруулсан гэж дүгнэжээ.⁸

Гурав. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр

Засгийн газрын хуралдаанаар “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр, энэ хүрээнд байгуулах үйлдвэрийн байршил, чиглэлийг баталлаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн Үндсэн чиглэлд тусгаж, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх заасан.⁹

Хөтөлбөр нь орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай, эрэлт хэрэгцээнд нийцсэн, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилготой.

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208271&showType=1>

⁹ “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн №36 тогтоол “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2018-2021) (Монгол Улсын Засгийн газрын 2021.10.13 №314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон)

Хөтөлбөр уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад салбарыг хамрах бөгөөд эхний шатыг 2018-2019, хоёрдугаар шатыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр зааж байжээ.

Монгол Улс 2017 оны жилийн эцсийн байдлаар 66.2 сая мал тоолуулж өмнөх оноос 9.9 хувиар өссөн нь малаас гаралтай түүхий эдийн нөөц нэмэгдэхээр байна. 2017 онд 373.1 мянган тонн мах, 803.4 сая литр сүү, 9400 тонн ноолуур, 29.0 мянган тонн ноос, 14.0 сая ширхэг арьс, шир бэлтгэжээ. Манай улсад түүхий эдийн гарал үүсэл тодорхойгүй, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшин хангалтгүй, техник, технологи хуучирсан, хүний нөөц дутагдалтай, чанар, стандартын хяналтын тогтолцоо бүрдээгүй, дэд бүтэц, ложистик хөгжөөгүй зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал байна. Иймээс дэвшилтэт технологийг нэвтрүүлж үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийг байгуулах, мэргэжилтэй ажилтан сургаж бэлтгэх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал байна.

Тус хөтөлбөрийн 4.1. Хөтөлбөрийн 2.3.1-д заасан зорилтын хүрээнд: 4.1.1. ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх, түүхий эдийн санг бий болгох, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор заажээ.

Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 2016 оны байдлаар 20 хувьтай байгааг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичигт зааснаар 60 хувьд хүргэхээр зорилт тавьж байжээ.

Ноолуур угаах, самнах үйлдвэр барих дотоодын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрт экспортыг нэмэгдүүлэх зорилт, хөрөнгийн хэмжээг тус хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршил чиглэлд мөн зааж байжээ.

“ҮЙЛДВЭРЖИЛТ 21-100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ 2021 оны жилийн эцсийн байдлаар дүгнэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яамнаас гаргажээ. Тус үнэлгээний тайланд¹⁰ дурдсанаар: Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин зорилтот түвшний 30 хувьд хүрсэн буюу 25 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэжээ.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлаас ноолуурын бүтээгдэхүүний үйлдвэржилтийг хөгжүүлэх чиглэлд хийгдсэн ажлыг дараах байдлаараа дүгнэжээ.

- Монгол Улсын Их хурлаас 2019 оны 3 дугаар сард баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуульд түүхий эдийн үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар хасалт хийх тухай 14.1.4 заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгосон.
- “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоолыг батлуулж, түүхий эдийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай 200.0 тэрбум төгрөг, МУХБ-ны эх үүсвэрээр олгох зээлийн хүүгийн зөрүүд 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Нийт 44 аж ахуйн нэгжид 103.9 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгөийн зориулалтаар олгосон. АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн Нэмэлт санхүүжилт төслөөс 2020 онд 2 үйлдвэрт 8.2 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7 хувийн хүүтэйгээр олгосон байна
- Арилжааны банкуудад 2021 онд ноолуур бэлтгэлийн зээлийн 178.1 тэрбум төгрөгийн 62 хүсэлт ирснээс 23 ААН-ийн зээлийг татгалзан, 38 ААН-д 94.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 10 ААН 17.1 тэрбум төгрөгийн дахин санхүүжилтэд багтсан байна
- Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран

¹⁰ “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийн үнэлгээ

<https://203.26.189.154/files/pdf-files/pdf/624aa28e5b58af779a8603bc.pdf>

бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан эскапортонд гаргаж эхэлсэн.

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Монголын тогтвортой ноолуурын платформоос ноолуурын салбарт олон талын оролцогчид (малчид, хоршоо, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчид, төрийн болон төрийн бус байгууллага, ШУ-ны байгууллага)-ыг хамруулсан нэмүү өртгийн сүлжээний бий болгох тогтолцоог судлаж, загвар боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлжээ.
- Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувь, 100 хувь арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 20 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 30 хувь, шинээр 81 үйлдвэр байгуулагдаж 4100 орчим ажлын байрыг бий болгосон байна.
- Ноос, ноолуурын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 203 аж ахуйн нэгж байна. Үүнээс 36 аж ахуйн нэгж нь экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа бөгөөд 28 нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30%-аас дээш хувийг экспортод гаргаж байна.
- Олон улсын MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулж, 19 нэр төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүнд чанарын баталгаажилт хийж эхэлсэн. ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-134 дугаар тушаалаар Монголын ноос ноолуурын холбоо ТББ-ыг ноос, ноолуурын салбарын тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагаар томилж, “Монголын хаан ширхэгт” чанарын гэрчлэх тэмдгийг олгох зарим эрх, үүргийг хэрэгжүүлэх 210914/06-476 дугаар гэрээг ХХААХҮЯ, МННХ-той байгуулан ажиллаж байна. “Монголын хаан ширхэгт” чанарын гэрчилэх тэмдгийг хэрэглэх эрхийг 3 ААН-д олгосон. Италийн ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг томоохон компаниуд болох “Colombo”, “Falconeri”-ийн захиалгаар “Ханбогд кашимер” ХХК нийт 20 тн ноолуур, үүнээс “Монголын хаан ширхэгт” чанарын

гэрчлэх тэмдгээр баталгаажсан 10 тн ноолуурыг Итали улс руу газраар тээвэрлэсэн.

- Ноолуур бэлтгэх зорилгоор нийт 44 аж ахуйн нэгжид 103,9 тэрбум төгрөгийн зээлийг МУХБ болон арилжааны банкуудаар дамжуулан олгосон. Тус яамнаас дээрх зээлийн 90% 17 хүүгийн зөрүү 9 хувийн хүү болох 5.1 тэрбум төгрөгийг 2020 онд олгожээ.
- Арилжааны банкууд 2021 онд ноолуур бэлтгэх 38 ААН-д 94.9 тэрбум, ноос бэлтгэх 4 ААН-д 3.2 тэрбум, арьс шир бэлтгэх 9 ААН-д 13.2 тэрбум нийт 51 аж ахуйн нэгжид 111,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Ноолуурын салбарын 10 ААН 17.1 тэрбум төгрөгийн дахин санхүүжилтэд багтсан байна. Улсын төсвөөс 2021 онд хүүгийн хөнгөлөлтөд 11.183 сая төгрөгийг арилжааны банкуудад олгожээ.
- Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан эскапортонд гаргаж эхэлсэн.
- Монголын ноос, ноолууран болон оёмол сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээл рүү татваргүй нийлүүлэх зорилго бүхий “Туравдагч хөршийн худалдааны хууль”-ийн төслийг 2018 оны 7 дугаар сарын 26-нд АНУ-ын Конгресст өргөн бариулж, түүнээс хойш батлуулахаар ажиллаж буй талаар тус тус хөтөлбөрийн үнэлгээний тайланд тусгажээ.

Дөрөв. Ноолуур хөтөлбөр (2018-2021)¹¹

Тус хөтөлбөрийг боловсруулах гол эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3-т Аж үйлдвэрийг хөгжүүлэх I үе шат (2016-2020 он)-нд “Нийт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх” гэж; Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.50-д “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэж; Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 2.1.10-д “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн энэхүү үндэсний хөтөлбөрийг боловсруулжээ.¹²

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2022 оны 3 дугаар сарын 15ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хийжээ. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг тус яамнаас дүгнэхдээ: “Ноолуур” хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 83.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв. Үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээний дүнгээр 32.2 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй дүгнэжээ.¹³ ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Батхүү өгсөн ярилцлагандаа: ..”хөтөлбөрийн

¹¹ “Ноолуур” хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоол “Ноолуур хөтөлбөр (2018-2021)” (*Монгол Улсын Засгийн газрын 2021.10.13 №314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон*)

¹² Сүүлд үзсэн: 2022.10.11

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=208271&showType=1>

¹³ “Ноолуур хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”: <https://203.26.189.154/files/pdf-files/pdf/624aa27e5b58af779a8603bb.pdf>

хэрэгжилтийн талаар нааштай байдлаар үнэлжээ. “Ноолуур” хөтөлбөр өнгөрсөн оноос амжилттай хэрэгжиж эхлэн, нийтдээ 1570 ажлын байрыг шинээр бий болгон, үйлдвэрлэлийн хүчин чадлыг 30 хувиар нэмэгдүүлээд байна. Ноолууран бүтээгдэхүүний борлуулалтын орлого өмнө нь 900 тэрбум төгрөг байсан бол өнгөрсөн жил 1.3 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн өндөр амжилтаар бид өнөөдөр Монгол Улсад Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн ойгоо угтаж байна гэжээ.¹⁴

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хийсэн байх бөгөөд (Тус үнэлгээтэй Хавсралт 2-оос бүрэн эхээр нь танилцана уу) тус үнэлгээнд дурдсанаар тус хөтөлбөрийн гол үр дүн, хэрэгжилтийг дараах байдлаар дүгнэжээ: “...“Ноолуур” хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 83.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв. Үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээний дүнгээр 32.2 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй дүгнэгдэж байна. Угаасан ноолуурын хэмжээг 2 дахин бууруулахаар төлөвлөсөн бол хөтөлбөрийн төгсгөлд экспортын хэмжээ өссөн байна. Харин самнасан ноолуур экспортын хэмжээ 3 дахин өсөхөөр төлөвлөсөн бол суурь түвшнээс буурсан байна. Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл зорилтот түвшний 28.8 хувьд хүрсэн бол хөтөлбөрийн хүрээнд шинээр нэмэгдэх байнгын ажлын байрны тоо 10,055-д хүрч зорилтот түвшинд бүрэн хүрсэн байна. ХХААХҮЯ-наас бодлогоор дэмжиж МУХБ-тай хамтран ажиллаж, гэрээ байгуулснаар ноолуурын үйлдвэрлэлийг дэмжихээр эргэлтийн хөрөнгийн 2020 онд ноолуур бэлтгэлд зориулан МУХБ-аас хүүгийн хөнгөлөлттэй 103.9 тэрбум төгрөгийн зээлийг 44 ААН-д олгосон. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 2021 онд ноолуур бэлтгэлийн зориулалтаар 38 ААН-д 94.9 тэрбум төгрөгийн зээл олгосон. Ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин /ээрэх хүчин чадлаар тооцоход/суурь онтой харьцуулахад 36,5 хувиар өсөж 2628 тн-д хүрсэн. Шалтгаан: Тайлант 2020, 2021 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал, бүтээгдэхүүний гадаад зах зээлийн

¹⁴ <https://montsame.mn/mn/read/204162>

үнийн бууралт, худалдан авах чадварын бууралт, экспортын тээвэрлэлт, үйлдвэрлэлийн сул зогсолт зэргээс шалтгаалж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Ололттой тал:

- “Монголын хаан ширхэгт” сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартыг шинээр боловсруулан СХЗГ-ын ноос, ноолуурын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулсан.
- МННХ-ны дэргэд “Баталгаажуулалтын албыг байгуулсан. Тус алба нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй МУ-ын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий байгууллага бий болгосон.
- Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн.
- Малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 203441 малчны тушаасан ноолуурт нийт 175.0 тэрбум төгрөгийн урамшуулал олгож дэмжлэг үзүүлсэн.
- Гадаадын төслүүд нь үйлдвэр аж ахуйн нэгж, хүрээлэн, хоршоодтой хамтран сургалт, судалгаа, туршилтын ажлуудыг орон нутагт, үйлдвэрлэл дээр зохион байгуулсан нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, чадавхижуулахад чухал нөлөө үзүүлсэн.
- Үйлдвэрүүд кластераар хамтран ажиллаж, бүтээгдэхүүнээ хөгжүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан бөгөөд дотоод, гадаадын зах зээл дээр бүтээгдэхүүнээ худалдан борлуулж байна.

Тус хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотойгоор дутагдалтай тал болон тулгамдсан асуудлыг “Боловсруулах үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн инженерийг тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд хамруулж тэтгэлэгтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдээгүй байна. Шинээр боловсруулж буй хөгжлийн зорилтот хөтөлбөрт ноолуурын салбарыг хөгжүүлэх чиглэлд зорилт, арга хэмжээ тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.” гэж дүгнэжээ.

“Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр ноолуурын эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 2018, 2019 онд давхардсан тоогоор

38 аж ахуйн нэгжид нийт 296.36 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.¹⁵

Монгол Улсад анх Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үндсэн зорилттойгоор Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан.

Үүний дараа нь Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталж анх 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хүчингүй болгожээ.¹⁶

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх үндсэн зорилготойгоор Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталжээ.¹⁷

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 45 дугаар тогтоолоор “2: Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд хугацааны хөгжлийн бодлого,

¹⁵ <https://www.parliament.mn/nn/10294/>

¹⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15408>

¹⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15403>

төлөвлөлтийн баримт бичгийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 6 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх” гэж заажээ.

Ийнхүү Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;” гэж заасныг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын 2021.10.13 №314 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

Тав. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичиг

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлах тухай 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 бодлогын баримт бичгийг баталсан.”¹⁸ Тус Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-ын 2.1.3. Аж үйлдвэрийн салбар, Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх I үе шат (2016-2020) Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэнэ гэж заажээ байжээ.

¹⁸ Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцжээ.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11725>

Зургаа. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай тогтоол гарч Монгол Улс түүхэнд анх удаа урт хугацааны хөгжлийн бодлогын томоохон баримт бичигтэй болсон билээ. Тус урт хугацааны хөгжлийн баримт бичигт:

“...Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.

Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

I үе шат (2021-2030): Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе.

2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.

6.Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна. ХАА-ын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр

4.2.7. Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ”

гэсэн томоохон зорилтод ажлыг тусгажээ. Түүнчлэн дархан арьс ширний цогцолбор ХХК арьс шир, ноос ноолуур боловсруулах томоохон үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх байгуулах жилдээ 10 сая ширхэг арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мянган тонн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний

цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн барилга байгууламжыг барьж байгуулахаар тусгажээ.

Энэ мэтээр ноолуурын салбарт эцсийн бүтээгдэхүүнийг экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чамгүй болон бодлого шийдвэрийг Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргаж хэрэгжүүлж байна.

--оОо--

Төрөөс ноолуурын салбарт оролцогчдын оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлд 2000 оноос хойш авч хэрэгжүүлсэн тухайлсан арга хэмжээ

Төрөөс ноолуурын салбарт оролцогчдын оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлд 2000 оноос хойш авч хэрэгжүүлсэн нэлээдгүй бодлогын баримт бичиг, хөтөлбөр арга хэмжээ байх бөгөөд эдгээрийг дараах байдлаар багцлан ангилж болохоор байна. Үүнд:

- Ноолуур бэлтгэн нийлүүлэгч малчдад чиглэсэн буюу ноолуурын үнийн талаарх бодлого, шийдвэр
- Ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн
- Ноолууран бүтээгдэхүүний худалдаа экспортыг нэмэгдүүлэх чиглэсэн гэж багцлан авч үзэж болохоор байна.

Нэг. Ноолуур бэлтгэн нийлүүлэгч малчдад чиглэсэн буюу ноолуурын үнийн талаарх бодлого, шийдвэр

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямрал болон цар тахал Ковид-19-өөс үүдэлтэйгээр ноолуур бэлтгэн нийлүүлэгчид буюу ялангуяа малчдад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хэд хэдэн бодлогын шийдвэрийг Монгол Улсын Засгийн газраас гаргаж, тухайн тухайн цаг үед нь хэрэгжүүлж байжээ. Ноолуурын үнэ тухайлбал 2007 онд дундажаар 32085 төгрөг байсанаа 2008 онд огцом буурч 14895 гэсэн дундаж

үнэтэй болсон. Үүнээс үүдэж иргэдийн ялангуяа малчин иргэдийн орлого, амьжиргааг хэвийн байдалд оруулах тулд тодорхой зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай хуулийг баталжээ. Тус хуулийн 1 дүгээр зүйлээр 2007 оны жилийн эцсийн мал тооллогын дүнг үндэслэн ямааны тоогоор тооцож нэг килограмм ноолуур тутамд 5000 төгрөгийг малчид болон мал бүхий иргэнд нэг удаа олгохоор зохицуулж байжээ. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан нэг удаагийн арга хэмжээнд шаардагдах 30.5 тэрбум /гучин тэрбум таван зуун сая/ төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу тус сангаас санхүүжүүлэхээр зааж байжээ.

Улмаар энэ шийдвэрийн нарийвчилсан дүнгээр нийт 18 сая 400 мянган ямаанд 24.7 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгохоор болсон байна.¹⁹

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн “Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 51 дүгээр тогтоолоор: Малчдын орлогыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хэрэглэгчдийн махны хангамжийг сайжруулах, ноолуурын үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор 1.2.чанар, зэрэглэлийг нь харгалзан 1 кг монгол ямааны ноолуурыг 30.000-32.000 төгрөгөөс доошгүй үнээр малчдаас худалдан авсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний аж ахуйн нэгжүүдэд Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасыг бүрэн олгох замаар зохион байгуулах; “малчдаас ноолуур худалдан авах үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газраас тодорхой журам гарган хэрэгжүүлэхээр зохицуулж байжээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай (Малчдаас ноолуур худалдан авах тухай)” 260 дугаартай тогтоолоор дээрх Улсын Их Хурлын 2008 оны 51 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний

¹⁹ Сангийн яамны Монгол улсыг хөгжүүлэх сангийн дарга Б.Нанзаддоржын ярилцлагаас: нийтлэгдсэн цахим эх сурвалж:

<http://factnews.mn/news/view/index/id/3315> сүүлд үзсэн: 2022.11.25

үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох журам"-ыг баталж, Монгол ямааны ноолуурын чанар, зэрэглэлийг харгалзан нэг килограммыг нь 30000-32000 мянган төгрөгөөр малчдаас худалдан авах үйл ажиллагааг шалгарсан үндэсний аж ахуйн нэгжүүдтэй хамтран нэн даруй эхлүүлж 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж шийдвэрлэж байжээ.

Тус Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоолын хавсралтаар “Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох” журамаар аж ахуй нэгжид эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох комиссын тодорхойлолтод тухайн аж ахуйн нэгж ноолуур боловсруулах үйлдвэрийг 3-аас доошгүй жил тогтвортой эрхэлсэн байх, мөн чанар, зэрэглэлийг харгалзан 17.5 микроноос дээшгүй нарийн голч бүхий нэг килограмм монгол ямааны ноолуурыг 30000-32000 мянган төгрөгөөр малчдаас болон малчин бүлгийн төлөөлөөс тухайн аймгийн төвөөс худалдан авах баталгаа гаргаж байхаар заасан.

Энэ арга хэмжээ нь нэг талаараа үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж буй мэт боловч үнэн хэрэгтээ үгүй байсан. Хятад улсын ченж нар мөн адил үнээр өрсөлдөж, ноолуурын үнийг хий хөөрөгдөлд оруулсан. Ингэснээр үндэсний үйлдвэрүүд болон жижиг дунд үйлдвэрлэгч нь нар түүхий эдээ авч чадахгүй байдалд хүрч байжээ.

Ийнхүү 2008 оны хямралын эдийн засгийн үед төрөөс ийнхүү малчин иргэдийн ахуй амьдралыг сайжруулах зорилгоор ноолуурын үнийг хүчээр барих, малчдад зөрүү мөнгө олгох зэрэг бодлого явуулсан ч энэ нь иргээд үйлдвэрлэл эрхлэгчдэд сөрөг үр дагаврыг авчирсан талаар судалаачид судалгааны бүтээлдээ дурджээ.²⁰

Мөн малчдын хоршоодод суурилан түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог сайжруулах зорилгоор Загвар хоршооны ТЭЗҮ-г хоршоодын мэргэжлийн холбоод болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай хамтран боловсруулж, хэрэгжүүлэхээр

²⁰ Ж.Мөнхгэрэл, Ж.Батжаргал, Б.Нармандах “Ноолуурын үнэ, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах, ноолууран эдлэлийн борлуултыг нэмэгдүүлэх нь” ШУТИС-Компютерийн техник Менежментийн сургууль нийтлэгдсэн цахим эх сурвалж: <https://www.slideshare.net/batnasanb/ss-31068739> сүүлд үзсэн: 2022.12.20

ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох тухай” 47 дугаар тогтоол батлагдсан ба тус тогтоолын дагуу Хөдөө аж ахуйн биржийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж эхлээд байна.²¹

Түүнчлэн 2019-2020 оны үед дэлхий дахиныг хамарсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаартай тогтоолыг баталсан. Тус тогтоолоор: 3. /малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн урамшууллыг Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох”-оор шийдвэрлэж байсан.

Өөрөөр хэлбэл тус тогтоолоор малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр тушаасан нэг килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөгийн урамшууллыг малчин өрх бүрт олгохоор шийдвэрлэж байжээ. Тус тогтоолын талаар УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд тайлбарлахдаа:²² “тушаасан ноолуурын кг тутамд 20 мянган төгрөгийн урамшуулал олгосноор 200 мянган малчин өрхийн 800 мянган иргэний орлогыг нэмэгдүүлж байгаа. Энэ нь аль аль талдаа амьдралд ойр, бодитой хувилбар юм гэжээ” Мөн Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан хэлэхдээ: “...ноолуурын үнэ ханш буурснаар малчдын орлого буурч байгааг харгалзан банкны зээлийн дарамтаас сэргийлж Засгийн газар Монголбанк бусад банктай

²¹ <https://www.parliament.mn/nn/10294/>

²² Ноолуур тушаасан суурь үнэ дээр кг тутамд 20.000 төгрөг нэмж олгох тогтоолын төсөл боловсруулжээ нийтлэгдсэн: <https://ikon.mn/n/1v8i> сүүлд үзсэн: 2022.12.11

⁹ “Төр ноолуурын кластерийн бэлтгэн нийлүүлэгчдийн дэмжсэн бодлого явуулж буй ган унтраах төдий шийдвэр” Нийтлэгдсэн: <https://ikon.mn/opinion/1vai> сүүлд үзсэн: 2022.12.20

ярилцаж, ажилласны хүчинд малчдын зээлийн төлбөрийг жилийн хугацаатай хойшлуулж, энэ хугацаанд хүү, алданги, торгууль тооцохгүй байхаар шийдсэн талаар хэлсэн билээ.²³

Судлаачдын хувьд зөвхөн малчдад дэмжлэг үзүүлэх байдлаар, ноолуурын үнийн зохицуулалт, урамшуулал олгох гэх мэт зохицуулалтыг төдийлөн сайшаадаггүй, шүүмжлэлтэй ханддаг байна. Тухайлбал судлаач, Ш.Энхтуул: “...Төрөөс баримталж буй бодлого нь нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь дэмжсэн байх шаардлагатай. Мөн дэмжихдээ өнөөгийн ноолуурын үнийн зохицуулалт хийж байгаа шиг механик зохицуулалтыг хийж болохгүйг анхаарах хэрэгтэй”²⁴ гэж дурджээ.

Хоёр. Ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн бодлого, шийдвэр

Ноолуурын салбарт үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн ялангуяа эдийн засгийн хувьд дэмжлэг болоход чиглэсэн үйлдвэрлэл явуулах, эцсийн бүтээгдэхүүн боловсруулах, улмаар экспортыг дэмжих зэрэг зорилгоор Монгол Улсын засгийн газраас бонд гаргах, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, татвараас чөлөөлөх, тэглэх зэрэг олон бодлого, шийдвэрийг авж хэрэгжүүлжээ.

Монгол Улсын хувьд “Дэлхийн хэмжээний ноолуурын нөөцийн 40 хувийг Монгол, 48 хувийг Хятад, 12 хувийг Иран, Афганистан зэрэг улс бэлтгэдэг. Манай ноолуурын салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 орчим ажилладаг. Ноос боловсруулах салбарт хивс үйлдвэрлэх хоёр, нэхэх дөрөв, ээрэх ес,

²³ <https://www.parliament.mn/nn/10294/>

²⁴ iKon.mn, Б. Даваабазар. “Төр Ноолуурын Кластерын Бэлтгэн Нийлүүлэгчдийг Дэмжсэн Бодлого Явуулж Буй Нь Гал Унтраах Төдий Шийдвэр”. ikon.mn, 2020-04-30. <https://ikon.mn/opinion/1vai>.

нэхээсгүй эдлэлийн нэг, угаах 25, хялгас ялгах 23, сүлжих 56, эсгий эдлэлийн 16, ноосон бордооны нэг, эсгийлэх 120, нийт 257 үйлдвэр ажилладаг” ажээ.²⁵

Монгол Улсад ноолуурын салбарт төрөөс авч хэрэгжүүлсэн томоохон бодлогын баримт бичиг болох Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дахь хөнгөлөлт чөлөөлөлтөөс эхлээд Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоолоор батлагдсан “Ноолуур хөтөлбөр (2018-2021), “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн №36 тогтоол “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2018-2021) зэрэгт туссан эрх зүйн зохицуулалт, авч хэрэгжүүлсэн олон ажил ноолуурын салбарт үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглэж байсныг мөн дээр дурдсан. Эдгээрээс эл хэсэгт ерөнхий бодлогын суурь баримт бичгүүдээс гадна тухайлсан эрх зүйн актуудад ноолуурын үйлдвэрлэл, үйлдвэрлэгчийг дэмжихэд чиглэсэн шийдвэр үйл ажиллагааг авч үзлээ.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн “Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 51 дүгээр тогтоолоор: Малчдын орлогыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хэрэглэгчдийн махны хангамжийг сайжруулах, ноолуурын үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор чанар, зэрэглэлийг нь харгалзан 1 кг монгол ямааны ноолуурыг 30.000-32.000 төгрөгөөс доошгүй үнээр малчдаас худалдан авсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний аж ахуйн нэгжүүдэд Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасыг бүрэн олгох замаар зохион байгуулах; “малчдаас ноолуур худалдан авах үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газраас тодорхой журам гарган хэрэгжүүлэхээр зохицуулж байсан.

Тус Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоолын хавсралтаар “Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд

²⁵ Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд хэлсэн мэдээллээс цахим эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/259587>

эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох” журамаар аж ахуй нэгжид эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох комиссын тодорхойлолтод тухайн аж ахуйн нэгж ноолуур боловсруулах үйлдвэрийг 3-аас доошгүй жил тогтвортой эрхэлсэн байх, мөн чанар, зэрэглэлийг харгалзан 17.5 микроноос дээшгүй нарийн голч бүхий нэг килограмм монгол ямааны ноолуурыг 30000-32000 мянган төгрөгөөр малчдаас болон малчин бүлгийн төлөөлөөс тухайн аймгийн төвөөс худалдан авах баталгаа гаргаж байхаар заасан.

Энэ арга хэмжээ нь нэг талаараа үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж буй мэт өөрөөр хэлбэл тодорхой үнэ тогтоон ноолуурыг худалдан авах байдлаар үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжих бодлого барьж төрөөс зохицуулалт хийсэн гэж үзэх үндэстэй ч зах зээлийн чөлөөт эдийн засгийн харилцаа зөрчигдөх, бусад өрсөлдөгч бэлтгэн нийлүүлэгчдээс үнийн өрсөлдөөн бий болгож улмаар үндэсний үйлдвэрүүд болон жижиг дунд үйлдвэрлэгч нь нар түүхий эдээ авч чадахгүй байдалд хүрэх сөрөг үр дагавар үүсгэж байжээ.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 30 дугаартай тогтоолоор: “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан 100 /нэг зуун/ тэрбум төгрөгийн,нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахаар шийдвэрлэж” байв.

Тус тогтоолын дагуу ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр 100 /нэг зуун/ тэрбум төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаатай олгожээ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг баталсан. Тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж ургаж, үржүүлсэн, олборлосон эсвэл импортын түүхий эдээр үнэ цэнэ шингээж боловсруулалт хийсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөөс дэмжих зорилготой гаргасан хууль. Энэ хуульд үйлдвэрлэлийг дэмжих үндсэн гурван дэмжлэгийг оруулсан. Нэгд, үйлдвэрлэсэн

бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгохоор заасан.

Хуулийн гол зорилго нь экспортын бүтцийг өөрчлөх буюу экспортын чиглэлийн баримжаатай үйлдвэрүүдийг дэмжихэд хоёр заалт байсан. Нэгдүгээрт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортолж байгаа үндэсний бүх үйлдвэрт техник технологийн шинэчлэл болон эргэлтийн хөрөнгөд гаргасан зардал, арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг улсаас олгох. Өөрөөр хэлбэл төрөөс бодлогоор гаргаж байгаа хүү 9-10 хувь, арилжааны банкнаас гаргаж байгаа хүү 18 хувь байна гэвэл зөрүүг нь Үйлдвэрүүдийг хөгжүүлэх сангаас буюу улсаас олгож дэмжих. Хоёрдугаарт, өндөр үр ашиг бүхий төсөл, технологи болон өндөр технологийг бий болгож нэвтрүүлээд экспортын бараа бүтээгдэхүүн болгож чадсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын 75 хүртэлх хувийг тухайн аж ахуйн нэгжид буцаан олгоё гэсэн заалт оруулсан.

Өөрөөр хэлбэл, Монгол Улс эдийн засгийн олон тулгуурт, бие даасан, тогтвортой хөгжилд шилжихийн тулд экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийг төрөөс онцгойлон анхаарч, нэгдсэн бодлого зохицуулалт, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагад нийцүүлэн уг хуулийг баталж байж. Энэ дагуу 2015 ондоо Үйлдвэрлэлийг дэмжих санг байгуулсан боловч тус сангийн дүрэм журам батлагдаагүйн улмаас сангийн үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй, үйл ажиллагаа явуулаагүй аж. Ийнхүү гадаадад экспортлогч томоохон үйлдвэрүүдээ дэмжих зорилгоор баталсан уг хууль хүчингүй болсон.

Засгийн газрын тусгай сангуудыг цэгцэлж, нэгтгэх зорилгоор Улсын Их Хурлаас 2019 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг шинэчлэн батлахдаа Үйлдвэрлэлийг дэмжих санг татан буулгаад зогсохгүй Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг [хүчингүй болгожээ](#). Энэ экспортыг дэмжих, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд баталсан чухал хууль байсан боловч 5 жилийн хугацаанд хэрэгжиж ч амжилгүй нэг ч аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэлгүй байсаар ийнхүү хүчингүй болжээ.

Шинэ коронавирусийн халдвар олон улсад тархаж, цар тахлын хэмжээнд хүрсэн. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар ноолуурын үнийн уналтаас хамгаалах, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, ажлын байрыг бууруулахгүй байх, экспортыг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 101 дүгээр тогтоолыг баталжээ. Тус тогтоол нь шинэ төрлийн коронавирусийн (Covid -19) халдвар олон улсад тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн онцгой нөхцөл байдал үүссэн энэ үед малчид болон боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийн аль, алинд нь үүсэх эрсдэлийг бууруулах, ноолуурын салбарыг дэмжих зорилготой юм.

Олон улсад шинэ коронавирус (Covid-19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлттэй уялдуулан зээлийн хүүг бууруулах арга хэмжээг авах, ноолуур бэлтгэхэд зориулан 300.0 (гурван зуун) хүртэл тэрбум төгрөгийн зээлийг нэг жилийн хугацаатай, зээлдэгч 3 хувийн хүү төлөх нөхцөлөөр Монгол Улсын Хөгжлийн банкнаас шууд болон арилжааны банкаар дамжуулан олгох үндсэн зээлийн хүү нь 12 хувь байсныг ноолуур бэлтгэх аж ахуйн нэгжид жилийн 3 хувийн хүүтэй 1 жилийн хугацаатай 300 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор заажээ.

Өөрөөр хэлбэл ноолууран түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, үнийг тогтвортой байлгах, үндэсний үйлдвэрлэгчдийг чанартай түүхий эд худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ноолуур бэлтгэлд зориулан ноолуур худалдан авагч үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд жилийн 3 хувийн хүүтэй 300 тэрбум төгрөгийн “Бодлогын зээл”-ийг Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр олгож байгаа бөгөөд зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 30 тэрбум төгрөгийг Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэхээр шийдвэрлээд байгааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд мэдээлэлдээ онцолжээ.²⁶

2021 оны 10 дугаар сард “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” нэгж байгуулагдаж аж ахуйн нэгжүүдэд зээл олгох үйл ажиллагаа үргэлжилж байгааг Х.Болорчулуун

²⁶ <https://www.parliament.mn/nn/10294/>

сайд мэдээлэлдээ дурдаад төслийн хугацаанд ноос, ноолуур, арьс шир, оёдол, мах, сүү, чацаргана болон жимс жимсгэнэ, зөгий, хүлэмжийн аж ахуй болон даршилсан ногоо, эрчимжсэн аж ахуй, үрийн үйлдвэрлэл салбарын 45 аж ахуйн нэгжид нийтдээ 106.8 тэрбум төгрөгийн зээл олгосныг онцолсон.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Дэлхийн банкны санхүүжилттэй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийг 2020-2025 онд 30.0 сая ам.долларын санхүүжилттэй хэрэгжүүлж буй бөгөөд тус төсөл нь Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв, Хэнтий, Дундговь аймгийн 80 сумдад хэрэгжиж байгаа ажээ.²⁷

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 19 дүгээр тогтоолоор: 1./ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттайгаар нэмэгдүүлэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, 2023 оноос хялгас ялгасаас дээш боловсруулалт хийсэн чанар, стандартын шаардлага хангасан ноолуурыг үйлдвэрлэх болон экспортлохтой холбоотойгоор үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх; 2./хялгас ялгасаас дээш боловсруулалт хийх зориулалттай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 3./хялгас ялгасан ноос, ноолуур, хөөвөр, ээрмэл утас болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаат, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр бүрдүүлэх; 5./байгаль орчинд ээлтэй, тогтвортой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөндлөнгийн итгэмжлэгдсэн

²⁷ УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар хийсэн мэдээлэлээс цахим эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/310429>

лабораторийн хүрээг өргөтгөн олон улсын түвшинд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх, ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ээр тус тус зохицуулжээ.

Засгийн газрын түвшний шийдвэрүүдийн хувьд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай (Малчдаас ноолуур худалдан авах тухай)” 260 дугаартай тогтоолоор “Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох журам”-ыг баталжээ. Улмаар Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоолын хавсралтаар “*Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох*” журамаар аж ахуй нэгжид эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох комиссын тодорхойлолтод тухайн аж ахуйн нэгж ноолуур боловсруулах үйлдвэрийг 3-аас доошгүй жил тогтвортой эрхэлсэн байхаар шаардлага тавьжээ.

Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 208 дугаар тогтоолоор Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан 100.0 (нэг зуун) тэрбум төгрөгийн, хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээд болон ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 50.0 (тавин) тэрбум төгрөгийн, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулан 150.0 (нэг зуун тавин) тэрбум төгрөгийн, нийт 300.0 хүртэлх тэрбум төгрөгийн үнэт цаасыг эх үүсвэрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан үе шаттай гаргах арга хэмжээ авахыг Сангийн сайдад зөвшөөрч шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн Журам батлах тухай (Ноолууран утас, ноос боловсруулах үйлдвэрийг дэмжих, урамшил олгох тухай) 221 дүгээр тогтоолоор “Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам”-ыг 1 дүгээр хавсралтаар баталжээ. Улмаар ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэсэн ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан 1р зэргийн хонины болон

тэмээний ноосонд мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд нарт үүрэг болгож шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай 125 дугаар тогтоолоор: “Ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрүүд түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх “Малчид болон ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд зээл олгох журам”-ыг боловсруулах асуудлыг шийдвэрлэж байжээ.

Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай 126 дугаар тогтоолоор “ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх урьдчилгаа төлбөрт зориулж 68.8 (жаран найман сая найман зуун мянган) сая хүртэлх ам.долларын зээлийг Хөгжлийн банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Ноолуурын салбарт дэмжлэг үзүүлэх тухай тогтоолоор “Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолын дагуу олгосон зээлийн чөлөөт үлдэгдлийг ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын төслийг дэмжих зорилгоор тухайн төслийн санхүүжилтийн 1/3-тэй тэнцэх зээлийг арилжааны банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэжээ.

Улмаар уг тогтоолын дагуу ноолуурын салбарын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэрт зориулан 68.8 сая ам.долларын зээлийг 5 жилийн хугацаатай олгожээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 149, 171 дүгээр тогтоолоор ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийн зээлд 100.0 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай зээлийг олгож байжээ.

Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор” “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолоор” Олон улсад шинэ коронавирус (Covid-19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай

холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлттэй уялдуулан зээлийн хүүг бууруулах арга хэмжээг авах, ноолуур бэлтгэхэд зориулан 300.0 (гурван зуун) хүртэл тэрбум төгрөгийн зээлийг нэг жилийн хугацаатай, зээлдэгч 3 хувийн хүү төлөх нөхцөлөөр Хөгжлийн банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Техникийн зохицуулалт батлах тухай 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хавсралтаар баталжээ. Техникийн зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтжээ. Ийнхүү Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолд зааснаар Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолын хавсралтаар “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг баталжээ.

Тус техникийн зохицуулалтын хүрээнд “Экспорт, импортын зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх ямааны ноолуур нь хялгас болон завсрын үсний агууламж 0.3 хувиас ихгүй байна” гэсэн зохицуулалтыг тусгасан нь зөвхөн самнасан ноолуурыг хилээр нэвтрүүлэх гол зохицуулалт болж байгаа юм.

Ноолуурын боловсруулалт, худалдаанд техникийн зохицуулалт хийснээр угаасан ноолуур экспортод гарахгүй, 4500 тонн хялгасыг нь ялгасан /самнасан/ ноолуур экспортолж, 2.1 сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн борлуулж, нийтдээ 660.0 сая ам.долларын борлуулалт хийж, салбарын борлуулалтын орлогыг 294 сая ам.доллароор нэмэгдүүлэх боломжтой ажээ.²⁸

Мөн “Эмээлт” хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк УИХ-ын 74 дүгээр тогтоолыг²⁹ хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 149 дүгээр тогтоолоор “Эмээлт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” /ЭХҮҮТП/ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн

28

<https://mofa.gov.mn/news/TIME/63b76de10527841f5c30e86f?fbclid=IwAR3lKsQBuuMPEUCQkm6OQ93awRF4KV0yssikkvvHquPCl75OVOxpN9M4dB8>

²⁹ УИХ-ын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9003>

газар /ОНӨААТҮГ/-ыг байгуулсан. Эмээлт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг арьс шир, ноос ноолуур зэрэг хөнгөн үйлдвэрийн чиглэлээр олон улсын жишигт нийцүүлэн кластераар хөгжүүлэхээр Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Шар хөцийн хоолойд нийт 160 га газарт барьж, байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажилд нь зориулж 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Энэхүү үйлдвэрлэл, технологийн парк нь байршлын хувьд авто зам, төмөр зам, нисэх буудлуудад ойрхон байрладаг тул үйлдвэрлэл хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой байрлал юм. Тус үйлдвэрлэл, технологийн парк нь арьс, шир, ноос ноолуурыг эцсийн бүтээгдэхүүн болгон бүх нэмүү өртгийг шингээн энэ салбарын нийт эргэлтийг 1 их наяд төгрөг хүртэл нэмэгдүүлэх боломжтой гэсэн тооцоог гаргасан байна. Хүчин чадлын хувьд арьс, шир боловсруулах 19, ноос, ноолуур угаах, самнах 8, дахин боловсруулах дэмжих 4, бэлэн бүтээгдэхүүний 4 үйлдвэр тус тус байрлаж, нийт 10,000 орчим ажлын байр бий болгохоор төлөвлөсөн байна. “Эмээлт” үйлдвэрлэл, технологийн паркийг бүрэн хүчин чадлаар нь ашиглалтанд оруулж бүх дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулахад нийт 300 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас үйл ажиллагаанд нь 14 шаардлагатай эхний ээлжийн дэд бүтцэд 58.6 сая ам.доллар, дараагийн ээлжийн буюу паркийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж эхлэхэд шаардлагатай дэд бүтцэд нийт 82.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэсэн тооцоо хийгдээд байгаа ажээ.³⁰

Гурав. Ноолууран бүтээгдэхүүний худалдаа экспортыг нэмэгдүүлэх чиглэсэн бодлого, шийдвэр

Энэ нь ноолуурын салбарт төрөөс авч хэрэгжүүлсэн томоохон бодлогын баримт бичиг болох Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 р дугаар сарын 14-ний

³⁰ Б.Эрдэнэбилэгт & Ц.Норовдондог. “Монгол улсын арьс, ширний түүхий эд бэлтгэлд төрөөс үзүүлж буй дэмжлэг, түүний боловсруулах үйлдвэрлэлд үзүүлж буй үр нөлөө болон гадаадын зарим орны туршлага”, Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын Газрын Мэдээлэл, Хяналт Шинжилгээ, Үнэлгээний Хэлтэс, 2017.

өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн №47 тогтоолоор батлагдсан. “Ноолуур хөтөлбөр (2018-2021)-т туссан зорилтод гол ажлын нэг нь нэмүү өртөг шингэсэн ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, гадаад худалдааг нэмэгдүүлэх чиглэсэн ажил байсан.

Манай улс бэлтгэсэн ноолуурынхаа 60-70 хувьд анхан шатны боловсруулалт хийж, угаасан байдлаар экспортолдог. Цаашид угаасан ноолуурын экспортыг багасгаж улмаар зогсоох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Монгол Улс дэлхийн түүхий ноолуурын 45 хувийг хангадаг боловч “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготой экспортолж буй ноолууран бүтээгдэхүүний дүнгээр дэлхийн зах зээлд 10 орчим хувийг эзэлж байна.

Монгол Улс дэлхийн түүхий ноолуурын 45 хувийг хангадаг боловч “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготой экспортолж буй ноолууран бүтээгдэхүүний дүнгээр дэлхийн зах зээлд 10 орчим хувийг эзэлж байна. 2020 оны 12 сарын байдлаар ноолуурын экспортын хэмжээ 243,5 сая ам.доллар байна. Ноолуурын нийт экспортын 76 хувийг угаасан, 7 хувийг боловсруулсан ноолуур, 17 хувийг эцсийн бүтээгдэхүүн эзэлжээ.³¹

Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувь, арьс, 100 ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 20 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 30 хувь, шинээр 81 үйлдвэр байгуулагдаж 4100 орчим ажлын байр бий болсон байна. Ноос, ноолуурын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 203 аж ахуйн нэгж байна. Үүнээс 36 аж ахуйн нэгж нь экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа бөгөөд 28 нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30%-аас дээш хувийг экспортод гаргаж байна.

Монгол Улсын ноолуур бэлтгэлийн хэмжээ ямааны тоо толгойноос хамаарч жилд дунджаар 10 мянган тонн хүрдэг. Манай улс нийт бэлтгэсэн ноолуурынхаа 70-80 хувийг зөвхөн угааж, 10 орчим хувийг самнасан байдлаар экспортолж, 10 гаруй хувийг бэлэн бүтээгдэхүүн болгон гадаад, дотоодын зах зээлд борлуулж байна. Харин

³¹ <https://itoim.mn/article/I0GfQ/27016>

нэхмэлийн салбарын нийт экспортын 90 гаруй хувийг ямааны ноолуур эзэлдэг. Манай улсад угаасан ноолуурын хялгасыг нь ялгах буюу самнах 40 үйлдвэрт 6017 тонн самнасан ноолуур гаргах хүчин чадал суурилагдсанаас 25 хувийн ашиглалттай байна. Өөрөөр хэлбэл, 12.035 тонн түүхий ноолуурыг угааж, хялгасыг нь ялгах хүчин чадал суурилагдаад байгаа нь жилдээ бэлтгэж буй 10.0 мянган тонн ноолуураа дотооддоо бүрэн самнах боломжтой гэжээ.³²

Анхны “Ноолуур” хөтөлбөрийг 2000-2004 онд хэрэгжүүлсний үр дүнд ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт эрчимтэй өсч, тухайн үеийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмрийг оруулсан.

Ноолуурын салбар төрөөс дэмжлэг авдаг хэдий ч үйлдвэрлэгчид маань гадны зах зээлд хангалттай борлуулалт хийдэггүйгээс энэхүү зах зээлд Хятадын хувь хүн, компаниуд монополь болчихсон бөгөөд жилдээ нийт түүхий ноолуурын 80 гаруй хувийг угаасан хэлбэрээр буюу хамгийн бага нэмүү өртөг шингэсэн хэлбэрээр экспортод гаргаж байна. Тэдгээр Хятадын компаниуд Монголд албан ёсоор компаниа бүртгүүлдэггүй, хөрөнгө оруулалт хийдэггүй, Монгол компаний нэр дээр экспорт хийдэг бөгөөд тухайн компанид маш бага хэмжээний үйлчилгээний хөлс төлж, татваргүй ноолуурыг авч оддог байна.³³

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай 2015.07.09 -ний өдөр батлагдсан хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Дараах барааг албан татвараас чөлөөлнө: 13.1.21. экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир; гэж заажээ.

³² Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарын мэдээлэлээс: Цахим эх сурвалж <https://mofa.gov.mn/news/TIME/63b76de10527841f5c30e86f?fbclid=IwAR3lKsQBu uMPEUCQkm6OQ93awRF4KV0yssikkvvHquPCI75OVOxpN9M4dB8> сүүлд үзсэн: 2023.01.19

³³ <https://ikon.mn/p/kue>

Өөрөөр хэлбэл монгол улсаас бусад улсад гаргаж буй түүхий болон угаасан, самнасан ноолуурыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалттай ажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулийн 14.1.4 дэх заалтад "хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр"-ийг нэмж өөрчлөлт оруулсан. Мөн хуулийн 14.2-т "14.1.4-т заасан анхдагч түүхий эдийг импортоор оруулсан буюу худалдан авч дамжуулан борлуулсан бол төлбөл зохих албан татвараас хасалт хийхгүй. Хоршоо гишүүнийхээ энэ хуулийн 14.1.4-т заасан барааг дотоодын үйлдвэрлэгчид зуучлан борлуулсан бол дамжуулан борлуулсанд тооцохгүй" гэсэн нэмэлт, өөрчлөлтийг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулжээ.³⁴

Ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас сүүлийн үед нэлээдгүй бодлогын шийдвэрийг баталжээ. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн "Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолыг баталжээ.

Тус тогтоолоор 1.Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд худалдан авалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд 3 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүү 200 тэрбум төгрөгийн зээлийг ноолуурын салбарт, 70 тэрбум төгрөгийн зээлийг ноосны салбарт олгох, дахин санхүүжүүлэх. Дахин санхүүжилтэд зориулан олгох зээлийн хэмжээ Компанийн тухай хуульд заасан хамаарал бүхий этгээдэд 10.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байхаар заажээ.2. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 2023 оноос угаасан ноолуурыг экспортлохгүй байх, самнаж боловсруулсан ноолуур, хялгасыг ялгасан ноолуурыг экспортлох, эдгээртэй холбоотой үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж мөрдүүлэх; 3.Ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлоход нэмэгдсэн өртгийн

³⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11227>

болон гаалийн албан татвараас чөлөөлөхтэй холбоотой асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх; 4.Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх талаар тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолоор: 1. /ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттайгаар нэмэгдүүлэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, 2023 оноос хялгас ялгахас дээш боловсруулалт хийсэн чанар, стандартын шаардлага хангасан ноолуурыг үйлдвэрлэх болон экспортлохтой холбоотойгоор үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх; 2. /хялгас ялгахас дээш боловсруулалт хийх зориулалттай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 3. /хялгас ялгасан ноос, ноолуур, хөөвөр, ээрмэл утас болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаат, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр бүрдүүлэх; 5./байгаль орчинд ээлтэй, тогтвортой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн хүрээг өргөтгөн олон улсын түвшинд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх, ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ээр тус тус зохицуулжээ.

Монгол Улсын Засгийн газраас ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих улмаар экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон бодлого шийдвэрийг тухай бүр гаргаж иржээ. Тухайлбал “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 87 дугаар тогтоол тус тогтоолын хавсралтаар “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. Энэ журмаар “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх

зорилгоор үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэлд зориулан агуулах дахь ноолуурын баталгаажсан үлдэгдлийг барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл олгох, улмаар ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх байнгын тогтолцоог бүрдүүлэх, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэлд зориулж банкнаас зээл олгох, зээлийн нөхцөл, хяналт тавих, агуулахын хөдөлгөөнийг бүртгэх, тайлагнах харилцааг зохицуулахаар заажээ.

Тус тогтоолын дагуу ноолуур угаах, самнах дамжлага бүхий үйлдвэрүүдэд ноолуур барьцаалан 1 жилийн 400 тэрбум төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгийн зээл олгожээ.

Түүнчлэн Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Жагсаалт батлах тухай 337 дугаар тогтоолоор (Экспортод гаргасан НӨАТ-ын хувь, хэмжээ 0 хувьтай тэнцүү байх эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг баталж Экспортод гаргасан нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь ("0")-тай тэнцүү байх ноос, ноолуур, арьс ширээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг баталжээ.

Сүүлийн үеийн буюу 2020 оноос хойшхи Засгийн газрын бодлого шийдвэрийн хувьд Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн "Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 178 дугаар тогтоолоор Түүхий ноолуур, ноос, арьс шир (адууны шириийг дэл, сүүлгүй)-ийг экспортлох ажлыг зохион байгуулахаар заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн "Алсын хараа-2050" монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай тогтоол гарч Монгол Улс түүхэнд анх удаа урт хугацааны хөгжлийн бодлогын томоохон баримт бичигтэй болсон билээ. Тус урт хугацааны хөгжлийн баримт бичигт: "...Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.

- Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

- I үе шат (2021-2030): Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе.
- 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.
- 6. Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна. ХАА-ын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр
- 4.2.7. Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ

гэсэн томоохон зорилтод ажлыг тусгажээ. Түүнчлэн Дархан арьс ширний цогцолбор ХХК арьс шир, ноос ноолуур боловсруулах томоохон үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх байгуулах жилдээ 10 сая ширхэг арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мянган тонн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулахаар тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын уул уурхайн бус салбарын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн экспортын чадавхыг сайжруулах, экспортын зах зээлийг тэлэх, “КОВИД-19” цар тахлын үр нөлөөллийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой “Экспортыг дэмжих төсөл” нь Дэлхийн банкны 20 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2016-2019 оныг дуустал Сангийн яаманд, 2020 оноос эхлэн ХХААХҮЯ-нд хэрэгжиж байгаа бөгөөд төслийн хэрэгжилт 72 хувьтай байгаа аж³⁵.

Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдөр “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль³⁶”-ийг баталсан. Тус хуульд бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тодорхойлолтыг үндэслэн урамшуулал олгох тухай заалт бий. Энэ нь түүхий эдээ боловсруулалгүй экспортлох явдлыг аль болох хязгаарлаж, дотооддоо боловсруулах зорилтыг хангахад чиглэгдсэн зохицуулалт юм.

³⁵ <https://montsame.mn/mn/read/310429>

³⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=567>

Түүнчлэн экспортыг нэмэгдүүлэх чиглэлд үе үеийн Засгийн газрын бодлого шийдвэр, томоохон хөтөлбөрүүдэд тусгасан зорилго, зорилтыг Засгийн газраас үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Техникийн зохицуулалт батлах тухай 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хавсралтаар баталсан.

Тус техникийн зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон. Уг тогтоолд “Экспорт, импортын зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх ямааны ноолуур нь хялгас болон завсрын үсний агууламж 0.3 хувиас ихгүй байна” гэсэн зохицуулалтыг тусгасан нь зөвхөн самнасан ноолуурыг 2023 оноос эхлэн улсын хилээр нэвтрүүлж экспортоор гаргахаар болоод байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Ийнхүү ноолуурын боловсруулалт, худалдаанд техникийн зохицуулалт хийснээр угаасан ноолуур экспортод гарахгүй, 4500 тонн хялгасыг нь ялгасан /самнасан/ ноолуур экспортолж, 2.1 сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн борлуулж, нийтдээ 660.0 сая ам.долларын борлуулалт хийж, салбарын борлуулалтын орлогыг 294 сая ам.доллараар нэмэгдүүлэх боломжтой. Түүнчлэн одоо байгаа 2200 ажлын байрыг тогтвортой хадгалж, 4400 орчим ажлын байр шинээр нэмэгдэнэ гэсэн тооцоолол гарсан. Улмаар угаасан ноолуур экспортолж буйг шатлал ахиулж, самнасан ноолуур экспортод гаргах болсон. Угаасан ноолуур бус самнасан ноолуур экспортолбол 4000-5000 ажлын байр бий болно. Угаасан ноолуураас Монгол Улсад өнгөрсөн жил 310 сая ам.доллар орж ирж байсан бол самнасан ноолуур экспортолсноор 500 сая ам.доллар болохоор байгаа талаар УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд Х.Болорчулуун мэдэгджээ.³⁷

Энэ мэтээр ноолуурын салбарт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тухайлбал, угаасан ноолуурын экспортоос самнасан, нэмүү өртөг шингэсэн ноолуурын экспортод чиглэсэн, ноолууран эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн гээд чамгүй олон бодлого шийдвэр, гадны донор

³⁷ <https://www.polit.mn/a/99761>

байгууллагын оролцоотой төсөл, хөтөлбөрүүдийг Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргаж хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн гол чухал нөлөөлөгч хүчин зүйл нь хөдөө аж ахуйн тэр дундаа уламжлалт нүүдлийн соёл, иргэншилд тулгуурласан бэлчээрийн мал аж ахуйд суурилсан мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ голлох байр суурийг эзэлдэг.

Тийм ч учраас мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих чиглэлд төрөөс олон тооны бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлж иржээ. Өөрөөр хэлбэл малчдын амьжиргааны гол эх үүсвэр болсон малчдын орлогын 40 хувийг бүрдүүлдэг ноолуурын асуудалд төрөөс онцгойлон анхаарч иржээ.

Энэ ч тухайн улсын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцааны суурь үндсийг тодорхойлдог Үндсэн хуульд хэрхэн тусгаснаас өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гэж зааж өгснөөс харж болно.

Монгол Улсын хувьд 1992 оноос зах зээлийн чөлөөт эдийн засгийн хэлбэрт шилжсэнээс эхлээд мал аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл, экспортод гаргах, үүнтэй холбоотой төрийн зүгээс авч хэрэгжүүлэх бодлого шийдвэр харьцангуй боловсронгуй болж батлагдан хэрэгжиж ирсэн түүхтэй.

Судалсан сэдвийн хүрээнд авч үзэхэд Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Ноолуур” хөтөлбөр 2000 хөтөлбөрийг анх баталсанаас эхлэн ноолуурын салбарын худалдаа, экспорт, бүтээгдэхүүн, түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт, экспортын бодлого түүнийг дагасан бодлого, шийдвэр 2000 оноос хойш нэлээдгүй гарчээ. Төрөөс ноолуурын салбарт оролцогчдын оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлд 2000 оноос хойш авч хэрэгжүүлсэн нэлээдгүй бодлогын баримт бичиг, хөтөлбөр арга хэмжээ байх бөгөөд эдгээр нь ноолуур бэлтгэн нийлүүлэгч малчдад чиглэсэн буюу ноолуурын үнийн талаарх

бодлого, шийдвэр, ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн, ноолууран бүтээгдэхүүний худалдаа экспортыг нэмэгдүүлэх чиглэсэн гэж ангилан тухайн тухайн чиглэлд төрөөс хэрэгжүүлсэн бодлого шийдвэр буюу эрх зүйн зохицуулалтын талаар энэхүү бэсрэг судалгааны лавлагаа мэдээлэлд оруулсан билээ.

Монгол Улсын хувьд 2000 оноос буюу анхны “ноолуур” хөтөлбөр батлагдсанаас хойш энэ салбарын хөгжил, оролцогчид болох малчид, бэлтгэн нийлүүлэгчид, худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн нэлээдгүй болон бодлогын шийдлүүдийг хийж холбогдох эрх зүйн акт шийдвэрийг гаргаж иржээ.

Эдгээрийг тоймлон дүгнэвэл малчдад чиглэсэн буюу ноолуурын үнийн талаарх бодлого, шийдвэрийн тухайд малчдын орлого багасах, түүхий ноолуурын худалдан авалт үнийн уналтаас сэргийлэх зорилгоор ноолуурын үнийн бодлогод төрөөс шууд оролцож үнийг тогтоох, малчдад ноолуурын худалдан борлуулалтын дүнгээр Засгийн газраас бодлогоор дэмжиж урамшуулал олгох байдлаар тухай тухайн цаг үед хэд хэдэн шийдвэр гаргаж байсан.

Дэлхийн нийтийг хамарсан болон үндэсний хэмжээнд үүссэн цаг үе, эдийн засгийн хямралтай нөхцөлөөс үүдэн ноолуурын үнэ буурах, үүдэж малчин иргэдийн орлого, амьжиргааг хэвийн байдалд оруулахын тулд тодорхой зарим арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2008 оны 51 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоол зэргээр ноолуурын үнийн зохицуулалт, урамшуулал олгох гэх мэт зохицуулалтыг хийж иржээ. Судлаачдын хувьд зөвхөн малчдад дэмжлэг үзүүлэх байдлаар, ноолуурын үнийн зохицуулалт, урамшуулал олгох гэх мэт зохицуулалтыг төдийлөн сайшаадаггүй, шүүмжлэлтэй ханддаг байна. Тухайлбал судлаач, Ш.Энхтуул: “...Төрөөс баримталж буй бодлого нь нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь дэмжсэн байх шаардлагатай. Мөн дэмжихдээ өнөөгийн ноолуурын үнийн зохицуулалт хийж

байгаа шиг механик зохицуулалтыг хийж болохгүйг анхаарах хэрэгтэй”³⁸ гэж дурджээ.

Харин сүүлийн үед хэрэгжүүлж буй бодлого шийдвэр нь малчид, бэлтгэн нийлүүлэгчдийн ноолуурын бэлтгэл, чанарт анхаарах³⁹, олон улсын чанарын шаардлагыг хангахуйц ноолуурыг бэлтгэх, эл ажлыг малчдын хоршооллын хэлбэрээр буюу зохион байгуулалтад оруулах зэрэгт түлхүү чиглэсэн бодлого шийдвэрийг явуулж байна. Тухайлбал, ганцхан жишээ дурдахад: Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “мөшгөгдсөн” ноолуурыг дэлхийн зах зээлд гаргаж эхэлсэн, “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн, 2023 оноос зөвхөн самнасан ноолуурыг л экспортод гаргах шийдвэр гарсан зэргийг гэх мэт дурьдаж болохоор байна.

³⁸ iKon.mn, Б. Даваабазар. “Төр Ноолуурын Кластерын Бэлтгэн Нийлүүлэгчдийг Дэмжсэн Бодлого Явуулж Буй Нь Гал Унтраах Төдий Шийдвэр”. ikon.mn, 2020-04-30. <https://ikon.mn/opinion/1vai>.

³⁹ Дам эшлэв.

<https://cdn.greensoft.mn/uploads/users/45/files/Handbook%20Mushgih%20togtoltsuu.pdf> “Хил Хязгааргүй Малын эмч нар ба Агрономчид” олон улсын байгууллага 2014 оноос хойш Баянхонгор аймгийн 5 суманд малчдын хоршоодтой хамтран ямааны ноолуурын үнэ цэнийг өсгөх, малчдын орлогыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой ноолуур бэлтгэх аргачлалыг боловсруулж гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэхээр тасралтгүй ажилласаар ирсэн” гэх мэт. Одоогийн байдлаар ТННЭ “Үлэмж Кашимер”, “Ханбогд” тэргүүтэй олон жилийн туршлагатай бэлтгэн нийлүүлэгчид болон 21 аймаг дахь малчдын хоршоодтой хамтран ажиллаж 2020 онд 90 гаруй тонн “мөшгөгдсөн” ноолуурыг дэлхийн зах зээлд нийлүүлсэн. Худалдан авагчдын дунд тогтвортой түүхий эдийн эрэлт нэмэгдэж байгаа тул ТННЭ 2024 он гэхэд 2,000 тонн ноолуур экспортлох зорилт тавин ажиллаж байна. Өнгөрсөн оны нийт экспортын 44.4 хувийг хамгийн том нийлүүлэгч болох Үлэмж Кашимер болон Ханбогд нар нийлүүлсэн бөгөөд ТННЭ-ийн сүлжээ холбосон сүлжээ өргөжихийн хэрээр эрэлт нь нийлүүлэлтээ давах дүр зураг харагдаж байна.

Харин ноолуурын салбарт авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийн хоёр дахь гол чиглэл бол ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн бодлого, шийдвэр юм. Энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн төрийн бодлого шийдвэр тэдгээрийн гол гол зохицуулалтын талаар судалгааны ажлын өмнөх хэсэгт дэлгэрэнгүй дурьдсан.

Энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэр мөн л чамгүй их байх бөгөөд гол дэмжлэг нь ноолуурын үндэсний үйлдвэрийг дэмжих, эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох зорилгоор, нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалах, бонд гаргах, зээлийн хүүг бууруулах зэргээр нэлээдгүй өндөр дүн бүхий зээлийг олгох байдлаар хэрэгжүүлж иржээ. Зөвхөн сүүлийн жишээг дурдахад л Засгийн газрын 117 болон 144 дүгээр тогтоолын хүрээнд 2022 онд 380 тэрбум төгрөгийн 1-2 жилийн хугацаатай, 3 хувийн хүүтэй, улсын төсвөөс 10.65 хувийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэний дотор ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд: 15.0 тэрбум гэж тусгаснаас харж болохоор байна. *(Өмнөх жилүүдэд ямар хэмжээний мөнгөн дүн бүхий зээлийг олгож байсныг өмнөх хэсэгт тухай бүр оруулсан болно.)*

Үүнийг нь ноолуурын салбарт, үйлдвэрлэл худалдаа эрхлэгчид ч хүлээн зөвшөөрдөг байна. Тухайлбал, Монголын Ноос, Ноолуур Бэлтгэн Нийлүүлэгчдийн Холбоог үүсгэн байгуулагч, "Үлэмж кашмир" ХХК-ны дэд захирал Г.Ариунжаргал: "...Миний харж байгаагаар ноолуурын салбар Төрөөс их хэмжээний хөнгөлөлттэй зээл авч байгаа. Ийм хэцүү үед хамгийн их анхаарч байгаа салбар яах аргагүй ноолуур. Тэгэхээр төр муу ажиллаж байна гэж ярьмааргүй байна."⁴⁰ гэсэн дүгнэлтээс харж болохоор байдаг.

Дараагийн төрөөс ноолуурын салбарт авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийн нэг үндсэн чиглэл бол яах аргагүй ноолууран бүтээгдэхүүний худалдаа, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого шийдвэр байдаг. Үүнд, Нэмэгдсэн өртгийн албан

⁴⁰ <https://ikon.mn/p/kue>

татварын тухай хуулийн зохицуулалтаар⁴¹ монгол улсаас бусад улсад гаргаж буй түүхий болон угаасан, самнасан ноолуурыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтаас эхлээд Улсын Их Хурал, Засгийн газрын урт, богино хугацааны, нэг удаагийн болон олон жилийн үйлчлэлтэй олон шийдвэрүүдэд ноолуурын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийг үндсэн гол зорилгоор тодорхойлж иржээ.

Төрөөс экспортыг нэмэгдүүлэх чиглэлд үе үеийн бодлого шийдвэрт тусгалаа олж ирсэн.

Гэхдээ гадаад зах зээл, экспортыг дэмжсэн бодлогын бичиг баримт байх боловч үйл ажиллагааг хөнгөвчлөх гэрээ хэлэлцээр дутмаг байгаа талаар мөн судлаачид дурьдах нь бий.⁴²

Мөн "Үлэмж кашмир" ХХК-ны дэд захирал Г.Ариунжаргал өөрийн ярилцагандаа: "...ноолуурын салбар төрөөс дэмжлэг авдаг хэдий ч үйлдвэрлэгчид маань гадны зах зээлд хангалттай борлуулалт хийдэггүйгээс энэхүү зах зээлд Хятадын хувь хүн, компаниуд монополь болчихсон бөгөөд жилдээ нийт түүхий ноолуурын 80 гаруй хувийг угаасан хэлбэрээр буюу хамгийн бага нэмүү өртөг шингэсэн хэлбэрээр экспортод гаргаж байна" гэж шүүмжлэлтэй хандсан нь бий.

Харин Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Техникийн зохицуулалт батлах тухай 380 дугаар тогтоолоор "Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг хавсралтаар баталсан. Тус техникийн зохицуулалтын хүрээнд "Экспорт, импортын зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх ямааны ноолуур нь хялгас болон завсрын үсний агууламж 0.3 хувиас ихгүй байна"

⁴¹ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө: 13.1.21.экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир; гэж заажээ.

⁴² МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш, докторант Ш.Энхтуул "төр өнөөдөр ноолуурын кластерын бэлтгэн нийлүүлэгчдээ дэмжсэн бодлого явуулж байгаа нь богино хугацааны, гал унтраасан шийдвэр болоод байна" гарчигтай нийтлэл. цахим эх сурвалж <https://ikon.mn/opinion/1vai> сүүлд үзсэн: 2022.12.10

гэсэн зохицуулалтыг тусгасан нь зөвхөн самнасан ноолуурыг улсын хилээр 2023 оноос экспортлохоор болоод байгаа юм.

Төрөөс ноолуурын экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого шийдвэрийг нэгтгэн дүгнэвэл олон урт болон богино хугацааны бодлогын баримт бичигт ноолуурын экспортыг нэмэгдүүлэх тодорхой хувьд хүргэх, эцсийн бүтээгдэхүүний экспортыг ихэсгэх, үйлдвэрлэлийг төдийгүй гадаад худалдааг дэмжихэд үндсэндээ чиглэж иржээ.

Хураангуй

Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2000 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн №50 тогтоолоор "...а./Ноолуур" хөтөлбөрийг 2000 оны II улиралд багтаан боловсруулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдад үүрэг болгосугай" гэж шийдвэрлэжээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан "Ноолуур" хөтөлбөрийг 2000-2004 онд хэрэгжүүлэхээр баталжээ.⁴³ Тус хөтөлбөрийг гурван үе шаттайгаар 2001-2006 оныг хамруулан хэрэгжүүлэхээр тусгажээ.

Үүний нэг илрэл нь 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлээр Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр зохицуулсан хуулийг баталжээ.

⁴³ Тус хөтөлбөрийг бүрэн эхээр нь тус холбоосоос үзнэ үү.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=201406&showType=1>

Хавсралт⁴⁴

МОНГОЛ УЛСАД НООЛУУРЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД
ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХУРААНГУЙ ТОЙМ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1	Эрх зүйн актын нэр: Монгол Улсын Үндсэн хууль⁴⁵ Огноо: 1992.01.13 Зохицуулсан харилцаа: Тавдугаар зүйлийн 1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.”, 2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, 3-т “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, 5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гэжээ Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байна
---	--

⁴⁴ Энэхүү эрх зүйн актын хураангуй түүвэр нь энэ чиглэлийн судалгаа хийхэд хялбар хэрэглэгдэхүүн болгох зорилгоор ноолуурын салбарт дам болон ялангуяа шууд хамаарах хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол тэдгээрийн гол агуулга зохицуулалтыг түүвэрлэсэн хураангуй болно. Эл түүвэрт багтсан эрх зүйн акт нь ноолуурын салбарт Монголд үйлчилж буй эсхүл хүчин төгөлдөр үйлчилж байгаад хүчингүй болсон эрх зүйн бүх акт шууд ойлгоход зарим талаар учир дутагдалтай байж болохыг анхаарна уу. Мөн тухай эрх зүйн актын талаар нарийвчлан, дэлгэрүүлж үзэхдээ нийтлэгдсэн эх сурвалжаас нь нягтлаж байхыг анхаарна уу.

⁴⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

2	Эрх зүйн актын нэр: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль⁴⁶ Огноо: 2011.06.02 Зохицуулсан харилцаа: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заажээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байна
3	Эрх зүйн актын нэр: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль⁴⁷ Огноо: 2015.07.09 Зохицуулсан харилцаа: Тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө: 13.1.21.экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир; гэж заажээ. Өөрөөр хэлбэл монгол улсаас бусад улсад гаргаж буй түүхий болон угаасан, самнасан ноолуурыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалттай ажээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
4	Эрх зүйн актын нэр: Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль⁴⁸ Огноо /дугаар/: 2020.08.28 Зохицуулсан харилцаа: 1 дүгээр зүйлээр “Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх”-өөр зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй

⁴⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=567>

⁴⁷ <https://legalinfo.mn/mn/detail/11227>

⁴⁸ <https://legalinfo.mn/mn/detail/15576>

5	Эрх зүйн актын нэр: Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хууль⁴⁹ Огноо /дугаар/: 2020.08.28 Зохицуулсан харилцаа: Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
6	Эрх зүйн актын нэр: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль⁵⁰ Огноо /дугаар/: 2020.08.28 Зохицуулсан харилцаа: Тус хуулийн 1 дүгээр зүйлд “Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжид тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний улиралд татвар төлөгчид буцаан олгох”-оор зохицуулжээ.

⁴⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15575>

⁵⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1557>

7	Эрх зүйн актын нэр: Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль⁵¹ Огноо: 2002.11.28 Зохицуулсан харилцаа: Тус хуулийн 4 дүгээр зүйлд “Хорио цээрийн хяналт, шалгалтад хамаарах зүйл” 4.1.Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна: 4.1.2.мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн;” хамаарахаар зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
8	Эрх зүйн актын нэр: Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай хууль⁵² Огноо: 2008.10.09 Зохицуулсан харилцаа: 1 дүгээр зүйлээр 2007 оны жилийн эцсийн мал тооллогын дүнг үндэслэн ямааны тоогоор тооцож нэг килограмм ноолуур тутамд 5000 төгрөгийг малчид болон мал бүхий иргэнд нэг удаа олгохоор зохицуулж байжээ. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан нэг удаагийн арга хэмжээнд шаардагдах 30.5 тэрбум /гучин тэрбум таван зуун сая/ төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу тус сангаас санхүүжүүлэхээр зааж байжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчингүй болсон

⁵¹ <https://legalinfo.mn/mn/detail/38>

⁵² <https://legalinfo.mn/mn/detail/316>

9	Эрх зүйн актын нэр: Иргэний хууль ⁵³ Огноо: 2002.01.10 Зохицуулсан харилцаа: 1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. 1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ. 1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татвар, төсөв, санхүү зэрэг захиргааны хууль тогтоомжоор зохицуулах болон захиргааны талаар нэг этгээд нөгөөдөө захирагдах эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй. Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа <i>Жи ч: Энэ хуульд ноолуурын талаар тухайлсан зохицуулалт байхгүй боловч зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулж буй гол хууль учир эл түүврийн хураангуй жагсаалтад зайлшгүй орох ёстой гэж үзэв.</i>
---	--

⁵³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=299>

10	Эрх зүйн актын нэр: Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль⁵⁴ Огноо: 2015.07.09 Зохицуулсан харилцаа: Өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэжээ. 3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж ургуулсан, өсгөж үржүүлсэн, олборлосон, эсхүл импортын түүхий эдээр үнэ цэнэ шингээж боловсруулалт хийсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих харилцаанд хамаарна. 3.2.Энэ хуульд заасан дэмжлэгт ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах үйл ажиллагаа хамаарахгүй. 3.3.Энэ хуульд заасан дэмжлэгт Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5-д заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд хамрагдахгүй. 3.4.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих харилцааг холбогдох хуулиар зохицуулна. Хүчин төгөлдөр байдал: Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцжээ.
----	---

⁵⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11226>

11	Эрх зүйн актын нэр: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль⁵⁵ Огноо: 2019.06.06 Зохицуулсан харилцаа: Энэ хуулийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэжээ. Энэ хууль нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд үзүүлэх төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулжээ. Хуулийн үйлчлэлд Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн ашиг олох зорилго бүхий дотоодын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид хамаарахаар заажээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа <i>Жи ч: Энэ хуульд ноолуурын салбарын талаар тухайлсан зохицуулалт байхгүй боловч жижиг дунд үйлдвэрлэл явуулах, тэдгээрт төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй гол хууль учир эл түгврийн хураангуй жагсаалтад зайлшгүй орох ёстой гэж үзэв.</i>
----	--

⁵⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14525>

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1	Эрх зүйн актын нэр: Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай⁵⁶ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол Огноо /дугаар/: 2008.05.30№51 Зохицуулсан харилцаа: Малчдын орлогыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хэрэглэгчдийн махны хангамжийг сайжруулах, ноолуурын үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор 1.2.чанар, зэрэглэлийг нь харгалзан 1 кг монгол ямааны ноолуурыг 30.000-32.000 төгрөгөөс доошгүй үнээр малчдаас худалдан авсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний аж ахуйн нэгжүүдэд Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасыг бүрэн олгох замаар зохион байгуулах; 1.3.малчдаас ноолуур худалдан авах үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газраас тодорхой журам гарган хэрэгжүүлэхээр зохицуулж байжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчингүй болсон
2	Эрх зүйн актын нэр: Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай⁵⁷ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол Огноо /дугаар/: 2011.06.03№30 Зохицуулсан харилцаа: Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан 100 /нэг зуун/ тэрбум төгрөгийн,нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрч зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчингүй болсон

⁵⁶ <https://legalinfo.mn/mn/detail/6202>

⁵⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=69898>

3	Эрх зүйн актын нэр: “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай⁵⁸ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол Огноо /дугаар/: 2020.05.13N^o52 Зохицуулсан харилцаа: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх урт хугацааны бодлогын баримт бичиг болно. Тус Зорилго 4.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно. Зорилт 4.2.Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. I үе шат (2021-2030): Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе 2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна 6.Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна Зорилт 4.5.Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. I үе шат (2021-2030): Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе 1.Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн байна. 2.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. II үе шат (2031-2040): Бүс нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бүс нутгийн нэмүү
---	---

⁵⁸ <https://legalinfo.mn/mn/detail/15406>

өртгийн сүлжээнд холбогдож ажиллах үе. 1.Бүс нутгийн эдийн засгийг дэмжих экспортын төрөлжилт бий болсон байна. 4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үнэ цэний сүлжээний санхүүжилтийн шинэчлэлийг хийж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, нүүдлийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. III үе шат (2041-2050): “Ухаалаг” хөдөө аж ахуйг хөгжүүлэх үе. 1.Шинжлэх ухаанд суурилсан ногоон үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ. 2.Хөдөө аж ахуйн салбарын судалгаа ба хөгжлийн тогтолцоог шинэчилж, биологийн нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдсэн биотехнологийн үйлдвэрлэлийг өргөжүүлнэ. 3.Оюуны багтаамж өндөртэй, органик, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр экспортыг нэмэгдүүлж, эдийн засагт орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ. 3.3.8. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (арьс ширний анхан шатны тордолтын цех, арьс ширэн жижиг эдлэлийн цех, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх, яс боловсруулах цех, сүлжмэлийн цех, эсгий, эсгий эдлэлийн цех, оёдлын цех, мод, модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох болон бусад); 2.ХАА-н бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх ХАА-Н бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 4.2.7. Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч: ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР ХХК Хөрөнгө оруулалт: ₮586 ТЭРБУМ Төслийн зорилго: АРЬС ШИР, НООС

	БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ТҮҮНИЙ ДЭД БҮТЦИЙГ БАЙГУУЛАХ ДАШЦ нь жилдээ 10 сая ширхэг арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мянган тонн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн барилга байгууламжыг барьж байгуулна. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй Жич: Энэхүү бодлогын баримт бичиг Монгол улсын тогтвортой хөгжлийн урт хугацааны томоохон бодлогын баримт бичиг бөгөөд судалгаанд хамаарах хүрээнд Монгол Улс цаашдаа экспортын бүтээгдэхүүний өсөлт, хөгжлийг дэмжих үүнд юун түрүүнд ноолууран бүтээгдэхүүний экспортыг улам бүр нэмэгдүүлэхэд чиглэх тул хамаарах гол гол зорилт, төлөвлөлтийг түүвэрлэн оруулсан болно.
4	Эрх зүйн актын нэр: Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай⁵⁹ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол Огноо /дугаар/: 2020.04.29№32 Зохицуулсан харилцаа: Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор “1./ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдуулан ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг яаралтай зохион байгуулах; 2./ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг "0" болгох асуудлыг шийдвэрлэх; 3./малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн урамшууллыг малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох; 4./ноолуурын зах зээлд өрсөлдөөнийг бий болгож, бодит үнэ тогтоох

⁵⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15310>

	зорилгоор гадаад улсын худалдан авагч нарыг ноолуур бэлтгэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг шуурхай зохион байгуулахаар” зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
5	Эрх зүйн актын нэр: “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Эрх зүйн актын төрөл: Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоол Огноо /дугаар/: 2021.04.06№02 Зохицуулсан харилцаа: Тус тогтоолд 1.Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд худалдан авалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд 3 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүү 200 тэрбум төгрөгийн зээлийг ноолуурын салбарт, 70 тэрбум төгрөгийн зээлийг ноосны салбарт олгох, дахин санхүүжүүлэх. Дахин санхүүжилтэнд зориулан олгох зээлийн хэмжээ Компанийн тухай хуульд заасан хамаарал бүхий этгээдэд 10.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байхаар заажээ. 2. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 2023 оноос угаасан ноолуурыг экспортлохгүй байх, самнаж боловсруулсан ноолуур, хялгасыг ялгасан ноолуурыг экспортлох, эдгээртэй холбоотой үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж мөрдүүлэх; 3.Ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлоход нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөхтэй холбоотой асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх; 4.Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх талаар тусгажээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
6	Эрх зүйн актын нэр: Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай⁶⁰ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол

⁶⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431>

	Огноо /дугаар/: 2021.12.30№106 Зохицуулсан харилцаа: "Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх болно. 3.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ." гэж тус тус зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй
7	Эрх зүйн актын нэр: Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай⁶¹ Эрх зүйн актын төрөл: Монгол Улсын Их Хурлын тогтоол Огноо /дугаар/: 2022.05.05№19 Зохицуулсан харилцаа: Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний

⁶¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=165304341423618>

үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 1./ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттайгаар нэмэгдүүлэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, 2023 оноос хялгас ялгахаас дээш боловсруулалт хийсэн чанар, стандартын шаардлага хангасан ноолуурыг үйлдвэрлэх болон экспортлохтой холбоотойгоор үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх; 2./хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх зориулалттай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 3./хялгас ялгасан ноос, ноолуур, хөөвөр, ээрмэл утас болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаат, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр бүрдүүлэх; 4./малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж боловсруулах үйлдвэрт тушаасан сарлагийн хөөвөр, торомны ноосны чанараас хамааруулан мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 5. /байгаль орчинд ээлтэй, тогтвортой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн хүрээг өргөтгөн олон улсын түвшинд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх, ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ээр зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байна.
--

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1	Эрх зүйн актын нэр: Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай⁶² Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/:1995.06.21/№101 Зохицуулсан харилцаа: а./аливаа хэрэглэгчтэй материал баялаг, эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүн /уур, ус, цахилгаан, дулааны эрчим хүч, шатахуун, тосолгооны материал, нүүрс, үр тариа, гурил, будаа, мах, сүү, алт, мөнгө, зэсийн баяжмал, ноос, ноолуур гэх мэт/-ийн тооцоог зөвхөн баталгаатай хэмжих хэрэгслээр хийж байх; Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байна.
2	Эрх зүйн актын нэр: Улсын хил хамгаалалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай⁶³ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/:1995.11.07/№202 Зохицуулсан харилцаа: хилийн албаны зохион байгуулалт, хилчдийн сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх замаар улсын хил хамгаалалтыг сайжруулж, хилээр автомашин, ноолуур болон бусад зүйл хууль бусаар гарган дамын наймаа хийж байгаа явдлыг таслан зогсоох шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэж байжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй үйлчлэлтэй.
3	Эрх зүйн актын нэр: Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай⁶⁴ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2000.03.30№50 Зохицуулсан харилцаа: Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанарыг

⁶² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=4929>

⁶³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=44858>

⁶⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=30958>

	сайжруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгоор а./"Ноолуур" хөтөлбөрийг 2000 оны II улиралд багтаан боловсруулах б./ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологийн түвшин, бүтээгдэхүүний чанарыг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран 2000 оны 5 дугаар сард багтаан аттестатчилах арга хэмжээ авах; 4.Ноолуурын салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг; 5.Ноолуур, ямааны арьсыг гүний болон байнгын ажиллагаатай гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр гаргахыг а./ямааны үүлдэрлэг байдал, сүргийн бүтцийг нарийвчлан тогтоож, нарийн ноолуур бүхий цөм сүргийг бүрдүүлэх, бүртгэл мэдээллийн сүлжээ бий болгох арга хэмжээ авах 9.Ноолуур, ямааны арьсыг экспортод гаргахад тавих төрийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд туслах, давхар хяналт тавих хөдөлгөөн өрнүүлж ажиллахыг холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрын удирдлагад зөвлөж тус тус шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй үйлчлэлтэй
4	Эрх зүйн актын нэр: Хөтөлбөр батлах тухай (Ноолуур хөтөлбөр⁶⁵) Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2000.07.14№64 Зохицуулсан харилцаа: "Ноолуур" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын ёсоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталжээ. Засгийн газрын 2000 оны 114 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Ноолуур хөтөлбөр-ийг баталсан. Хүчин төгөлдөр байдал: Үйлчлэл нь дуусгавар болсон
5	Эрх зүйн актын нэр: Тогтоолд өөрчлөлт оруулах тухай⁶⁶ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол

⁶⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=50058>

⁶⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=104168>

	Огноо /дугаар/: 2000.12.26№199 Зохицуулсан харилцаа: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийг сэргээх, экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Ноолуур" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажилд шаардлагатай зардлын хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталжээ. Хүчин төгөлдөр байдал: Үйлчлэл нь дуусгавар болсон
6	Эрх зүйн актын нэр: Төлөвлөгөө батлах тухай (Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)⁶⁷ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2008.02.20№64 Хүчин төгөлдөр байдал: Үйлчлэл нь дуусгавар болсон
7	Эрх зүйн актын нэр: Журам батлах тухай (Малчдаас ноолуур худалдан авах тухай)⁶⁸ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2008.06.18№260 Зохицуулсан харилцаа: Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 51 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 1. "Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох журам"-ыг баталжээ. 2. Малчдаас зах зээлд борлуулаагүй монгол ямааны ноолуурын үлдэгдлийн талаарх мэдээг сум бүрээр гаргаж 2008 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай. 3. Малчдаас ноолуур худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, ноолуурын зах зээлийн үнийг тогтворжуулахад хяналт тавих комиссыг нутгийн захиргааны үйлдвэрлэгч байгууллага, ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний

⁶⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=42038>

⁶⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=2656&>

	үйлдвэрлэгч, малчдын төлөөлөлтэйгээр аймаг бүрт байгуулан ажиллуулахыг; 4. Монгол ямааны ноолуурын чанар, зэрэглэлийг харгалзан нэг килограммыг нь 30000-32000 мянган төгрөгөөр малчдаас худалдан авах үйл ажиллагааг шалгарсан үндэсний аж ахуйн нэгжүүдтэй хамтран нэн даруй эхлүүлж 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж 5. Сонгон шалгарсан үндэсний аж ахуйн нэгжийг эргэлтийн хөрөнгөөр тааламжтай нөхцөлөөр хангахад чиглэсэн гурван талт санамж бичгийг Монголын банкуудын холбоо, Монголын ноос, ноолуурын холбоотой зөвшилцөн байгуулж ажиллах арга хэмжээ авахыг Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайд нарт даалгаж шийдвэрлэжээ. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоолын хавсралт “Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох” журам Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
8	Эрх зүйн актын нэр: Засгийн газрын үнэт цаас гаргах тухай ⁶⁹ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2011.07.06N°208 Зохицуулсан харилцаа: Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан 100.0 (нэг зуун) тэрбум төгрөгийн, хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээд болон ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 50.0 (тавин) тэрбум төгрөгийн, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулан 150.0 (нэг зуун тавин) тэрбум төгрөгийн, нийт 300.0 хүртэлх тэрбум төгрөгийн үнэт цаасыг эх үүсвэрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан үе шаттай гаргах арга хэмжээ авахыг Сангийн сайдад зөвшөөрч шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь

⁶⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=30098>

	дуусгавар болсон
9	Эрх зүйн актын нэр: Журам батлах тухай (Ноолууран утас, ноос боловсруулах үйлдвэрийг дэмжих, урамшил олгох тухай)⁷⁰ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2011.07.06№221 Зохицуулсан харилцаа: "Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам"-ыг 1 дүгээр хавсралтаар баталжээ. Улмаар Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэн ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан 1р зэргийн хонины болон тэмээний ноосонд мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд нарт үүрэг болгож шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
10	Эрх зүйн актын нэр: Эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай⁷¹ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2013.03.30№125 Зохицуулсан харилцаа: Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрүүд түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайдад зөвшөөрч, "Малчид болон ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд зээл олгох журам"-ыг боловсруулж Засгийн газарт оруулах арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд нарт даалгаж шийдвэрлэж байжээ.

⁷⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=27168>

⁷¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=91408>

	Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
11	Эрх зүйн актын нэр: Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай ⁷² Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2013.03.30№126 Зохицуулсан харилцаа: Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх урьдчилгаа төлбөрт зориулж 68.8 (жаран найман сая найман зуун мянган) сая хүртэлх ам.долларын зээлийг Хөгжлийн банкаар дамжуулан олгохыг Эдийн засгийн хөгжлийн сайдад даалгах Ноолуурын салбарт хийх технологийн шинэчлэлийг экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулан зохион байгуулж, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдэд үүрэг болгож шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
12	Эрх зүйн актын нэр: Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай ⁷³ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2013.09.21№324 Зохицуулсан харилцаа: Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулан гаргасан Засгийн газрын үнэт цаасны хугацааг Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр заалтад заасан хугацаатай нийцүүлэх зорилгоор 290.1 (хоёр зуун ерэн тэрбум нэг зуун

⁷² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=91418>

⁷³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=94118>

	сая) тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалахыг Сангийн сайдад даалгаж шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
13	Эрх зүйн актын нэр: Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай⁷⁴ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2014.03.21№87 Зохицуулсан харилцаа: Монгол Улсад бэлтгэсэн ноолуурыг боловсруулж, олон улсын зах зээлд нэгдсэн зохион байгуулалттайгаар экспортлох арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад даалгаж, "Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам"-ыг тус тогтоолын хавсралтаар баталжээ. <i>"Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам"</i>⁷⁵ Энэ журмаар "Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэлд зориулан агуулах дахь ноолуурын баталгаажсан үлдэгдлийг барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл олгох, улмаар ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх байнгын тогтолцоог бүрдүүлэх, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэлд зориулж банкнаас зээл олгох, зээлийн нөхцөл, хяналт тавих, агуулахын хөдөлгөөнийг бүртгэх, тайлагнах харилцаа"-г энэхүү журмаар зохицуулжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
14	Эрх зүйн актын нэр: Ноолуурын салбарт дэмжлэг үзүүлэх тухай⁷⁶ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол

⁷⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=98748>

⁷⁵ ²⁸¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15399>

⁷⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=104078>

	Огноо /дугаар/: 2014.05.26№165 Зохицуулсан харилцаа: "Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай" Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолын дагуу олгосон зээлийн чөлөөт үлдэгдлийг ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын төслийг дэмжих зорилгоор тухайн төслийн санхүүжилтийн 1/3-тэй тэнцэх зээлийг арилжааны банкаар дамжуулан олгохыг Эдийн засгийн хөгжлийн сайдад даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрчээ. Улмаар "Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай" Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлийн дагуу олгосон зээлд мөрдөхгүй байхаар тогтоожээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
15	Эрх зүйн актын нэр: Жагсаалт батлах тухай (Экспортод гаргасан НӨАТ-ын хувь, хэмжээ 0 хувьтай тэнцүү байх эцсийн бүтээгдэхүүний жагсаалт)⁷⁷ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2015.08.17№337 Зохицуулсан харилцаа: Экспортод гаргасан нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь ("0")-тай тэнцүү байх ноос, ноолуур, арьс ширээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг тус тогтоолын хавсралтаар баталжээ. <i>Экспортод гаргасан нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь ("0")-тай тэнцүү байх ноос, ноолуур, арьс ширээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний жагсаалт Нэг. Ноос, ноолууран эцсийн бүтээгдэхүүн</i> Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр
	Эрх зүйн актын нэр: "Ноолуур" хөтөлбөр батлах тухай⁷⁸ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2018.02.06 №47 Засгийн газрын 2018 оны 47 дугаар

⁷⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=112878>

⁷⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13204>

	тогтоолын хавсралтаар Ноолуур хөтөлбөр (2018-2021) баталсан Зохицуулсан харилцаа: “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3-т Аж үйлдвэрийг хөгжүүлэх I үе шат (2016-2020 он)-нд “Нийт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх” гэж; Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.50-д “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэж; Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 2.1.10-д “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасныг тус тус үндэслэн энэхүү үндэсний хөтөлбөрийг боловсруулжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчингүй болсон
16	Эрх зүйн актын нэр: Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай⁷⁹ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2020.03.19№101 Зохицуулсан харилцаа: Олон улсад шинэ коронавирус (Covid-19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлттэй уялдуулан зээлийн хүүг бууруулах арга хэмжээг авах, ноолуур бэлтгэхэд зориулан 300.0 (гурван зуун) хүртэл тэрбум төгрөгийн зээлийг нэг жилийн хугацаатай, зээлдэгч 3 хувийн хүү төлөх нөхцөлөөр олгох, түүхий эд барьцаалах, зээлдэгчийн бонд болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалсны үндсэн дээр Хөгжлийн банкны

⁷⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=152028>

	болон арилжааны банкны эх үүсвэрээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх талаар арга хэмжээ авахыг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл-д зөвлөж шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
17	Эрх зүйн актын нэр: Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай⁸⁰ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2020.05.06№167 Зохицуулсан харилцаа: Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг "Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага" (MNS 0550:2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20 000 (хорин мянган) төгрөгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгаж шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
18	Эрх зүйн актын нэр: Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай⁸¹ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2020.05.13№178 Зохицуулсан харилцаа: Түүхий ноолуур, ноос, арьс шир (адууны ширийг дэл, сүүлгүй)-ийг экспортлох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т тус тус даалгасугай.

⁸⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=153588>

⁸¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15399>

	Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт", Засгийн газрын 2014 оны 87 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам"-ын 8.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ын 51.05 дахь заалтыг 1 жилийн хугацаатай тус тус түдгэлзүүлсүгэй. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
19	Эрх зүйн актын нэр: Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай⁸² Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2021.07.28№211 Зохицуулсан харилцаа: Тус тогтоолоор Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авах хариу арга хэмжээний талаар дор дурдсан ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт “Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арьс шир, ноолуурын түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх ажлын төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжилтийг хангах;” ажлыг зохион байгуулахыг даалгаж шийдвэрлэжээ. Хүчин төгөлдөр байдал: Нэг удаагийн шинжтэй хүчин төгөлдөр үйлчлэл нь дуусгавар болсон
20	Эрх зүйн актын нэр: Техникийн зохицуулалт батлах тухай⁸³ Эрх зүйн актын төрөл: Засгийн газрын тогтоол Огноо /дугаар/: 2022.10.19№380 Зохицуулсан харилцаа: Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хавсралтаар баталжээ. Техникийн

⁸² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=162310850062218>

⁸³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=165316896301518>

	зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтжээ. Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолын хавсралтаар “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг баталжээ. Хүчин төгөлдөр байдал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа
--	--